



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ҮР НӨЛӨӨГӨӨР ТАТВАРЫН БААЗ
ӨРГӨЖИЖ, ТӨСВИЙН ОРЛОГО ӨССӨН БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: АНУЗГ-2023/23-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал,
тэргүүлэх аудитор Я.Самбууням

Утас: 263755, цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитын менежер Ц.Бат-Өлзий

Утас: 261805, цахим хаяг: bat-ulziits@audit.gov.mn

Мэдээлэл технологийн төвийн захирал Д.Энхтуяа

Утас: 261805, цахим хаяг: enkhuyad@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батчимэг

Утас: 261456, цахим хаяг: bachimegb@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Мөнхцацрал

Утас: 261456, цахим хаяг: munktsatsrall@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Эрдэнэбат

Утас: 261456, цахим хаяг: erdenebatb@audit.gov.mn

Ахлах аудитор Э.Энхбаатар

Утас: 261675, цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхтуяа

Утас: 261675, цахим хаяг: munkhtuyab@audit.gov.mn

Аудитор Т.Нямсүрэн

Утас: 261456, цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn

Аудитор М.Баяртогтох

Утас: 262451, цахим хаяг: bayartogtokhm@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Татварын Ерөнхий газар газар, Гаалийн ерөнхий газарт тус тус хүргүүлэхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд (Б.Жавхлан)-д зөвлөж, Татварын Ерөнхий газрын дарга (Б.Заяабал), Гаалийн ерөнхий газрын дарга (Р.Отгонжаргал) нарт даалгасугай.

4. Аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, танилцуулга хийхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

0001010783

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн товъёг	6
Дүрслэлийн товъёг	6
Хавсралтын товъёг	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	7
Ерөнхий мэдээлэл.....	9
БҮЛЭГ 1. ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГОД ТУЛГУУРЛАН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЭДИЙ Ч ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	11
1.1 Татварын шинэчлэлд баримтлах бодлогод оролцогч талуудын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийн уялдааг хангах, хэрэгжилтийг хянаж, нэгтгэн дүгнэх шаардлагатай байна.	11
1.2 Татварын шинэчлэлийн хүрээнд багц хуулиудыг шинэчлэн баталж, холбогдох 28 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан боловч зарим татварын хуулийг шинээр боловсруулах, татварын хуулийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.....	12
БҮЛЭГ 2. ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАГДАХ ЭРХ САЙЖИРЧ ТӨСВИЙН ОРЛОГО ӨССӨН БОЛОВЧ ТАТВАРЫН АЧААЛАЛ НЭМЭГДСЭН БАЙНА.	14
2.1 Нэгдсэн төсвийн нийт орлогын 70 гаруй хувийг татварын орлого бүрдүүлж, 2019-2022 онд 5,050.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.	14
2.2 Татварын ачаалал болон инфляцын түвшин өсөж байгаа нь татварын шинэчлэлийн “эдийн засгийг сэргээх, иргэдийн амьдралыг дэмжих” бодлогын үр нөлөөг сулруулж байна.	15
2.3 Мэдээлэл технологийн шинэчлэлийг татварын хуулийн шинэчлэлтэй уялдуулж зохион байгуулснаар, татварын байгууллагын мэдээлэл авах эрх сайжирч, далд эдийн засгийн хэмжээ буурсан байна.	16
БҮЛЭГ 3. ТАТВАРЫН ОРЛОГЫГ ХУВААРИЛАХ, БҮРТГЭЖ ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗААЛТАД НИЙЦҮҮЛЖ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	18
3.1 Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд татвар төлөгчдөд таатай нөхцөлийг бий болгосон хэдий ч зарим тодорхойгүй зохицуулалтуудыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна.	18
3.2 Татварын орлогоос хуульд заасан хэмжээгээр орон нутгийн төсөвт хуваарилаагүй, орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуулиар олгогдсон эрхийн хүрээнд татварын хувь хэмжээг харилцан адилгүй тогтоож байна.	19
3.3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн татварын шинэчлэл хийхээс өмнөх 2019 онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн боловч хувиараа бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, татвар ногдуулалт, хураалт, цахим и-баримт олголт хангалтгүй байна.	21
БҮЛЭГ 4. ТАТВАРЫН ӨР 2022 ОНЫ БАЙДЛААР 3,276.6 ТЭРБУМ ТӨГРӨГ БОЛЖ ӨССӨН НЬ КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛААС ШАЛТГААЛСАН БАЙНА.	24
4.2 Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа нэг үе шаттай болж, татвар төлөгчдөд чирэгдэл багатай үйлчлэх нөхцөл бүрдсэн байна.	26
БҮЛЭГ 5. ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРГӨЖИЖ, ТАТВАРЫН ЗОРИЛГООР ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СТАНДАРТ, ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ISO/IEC 27001:2013 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛСЭН БАЙНА.....	27
5.2 ТЕГ татвар төлөгч, татварын албаны мэдээллийн нууцлагдсан, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001:2013 стандарт, Татварын зорилгоор харилцан мэдээлэл солилцох стандарт, гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	28
5.3 Төрийн болон албаны нууц мэдээлэлд нэвтрэх албан тушаалтанд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр эрх олгосон байна.....	29
5.4 Олон улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, Дэлхийн 26 улстай байгуулсан давхар татварын гэрээг мөрдөж байна.	30

5.5	ТЕХ-ийн шинэчилсэн зохицуулалтын дагуу харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн бараа, ажил үйлчилгээний нөхцөл, үнийг тодорхойлсон “үнэ шилжилтийн 3 төрлийн тайлан”-г хянаж, хүлээн авч байна.....	31
	БҮЛЭГ 6 ТАТВАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛЖ ХҮНИЙ ОРОЛЦООГҮЙГЭЭР, БОГИНО ХУГАЦААНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.	32
	АУДИТЫН ҮР ДҮН.....	32
	ДҮГНЭЛТ:.....	33
	ЗӨВЛӨМЖ:.....	34
	Хавсралтууд	35

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТХ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АНЗДТГ	Аймаг нийслэлийн засаг даргын тамгын газар
АТБӨЯХАТХ	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГТГТТХ-	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАБ	Мэдээллийн аюулгүй байдал
МТТ	Мэдээлэл технологийн төв
МУ	Монгол Улс
МУЕС	Монгол Улсын Ерөнхий Сайд
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МУНТГ	Монгол Улсын Нэгдсэн Төсвийн гүйцэтгэл
МУНТГТ	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой байдлын үзэл баримтлал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НӨАТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НТГ	Нийслэлийн татварын газар
ТаЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТБАНТХ	Төрийн болон албаны нууцын тухай хууль
ТБМНС	Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЕХ	Татварын ерөнхий хууль
ТЗТБ	Төрийн захиргааны төв байгууллага
ТМТЗ	Татварын маргаан таслах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТ	Татвар төлөгч
ТУНС	Татварын удирдлагын нэгдсэн систем
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УҮГ	Улсын үйлдвэрийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХЭХАТХ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
ҮШТ	Үнэ шилжилтийн тайлан
ХТТХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ХХОАТХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1. Төсөвт үзүүлэх татварын орлогын нөлөө, /тэрбум төгрөгөөр/.....	14
Хүснэгт 2. Татварын орлогын бүрэлдэхүүн, /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 3. Далд эдийн засгийн хэмжээ	16
Хүснэгт 4. Татвар төлөгчийн бүртгэл	17
Хүснэгт 5. Татвар ногдуулах хөрөнгийн тоо.....	17
Хүснэгт 6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн ирцийн мэдээ	17
Хүснэгт 7. ААНОАТ-ын хуулийн суурьд орсон өөрчлөлт	18
Хүснэгт 8. ААНОАТ-ын хуваарилалт, /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 9. Орон нутгийн төсвийн орлого, /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 10. МУНТГ-ийн тайлан, ТБМНС-ийн татварын орлого, /тэрбум төгрөгөөр/	21
Хүснэгт 11. Татварын зарлага, /тэрбум төгрөгөөр/.....	22
Хүснэгт 12. Татварын буцаан олголт, /тэрбум төгрөгөөр/.....	23
Хүснэгт 13. Төлөлт удааширсан гаалийн албан татвар, /тэрбум төгрөгөөр/.....	23
Хүснэгт 14.Татварын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөгөөр/.....	24
Хүснэгт 15. Хүндрэлтэй өрийн хэмжээг хассан татварын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөгөөр/.....	25
Хүснэгт 16. Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт	26
Хүснэгт 17. Хөндлөнгийн мэдээллийн сангийн бүрдэлтийн талаарх мэдээлэл.....	27
Хүснэгт 18. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний дүн	29
Хүснэгт 19.ААНОАТ-ын тайлангаар гадаад улсад ногдуулан төлсөн албан татвараа хасаж тооцсон мэдээлэл, дүн, /тэрбум төгрөгөөр/	31

Дүрслэлийн товьёг

Дүрслэл 1. Татварын шинэчлэлийн орчин.....	9
Дүрслэл 2. Татварын шинэчлэлийн бодлогын баримт бичиг.....	11
Дүрслэл 3. Татварын орлогын бүрдүүлэлт, /хувиар/	15
Дүрслэл 4. ДНБ-д эзлэх татварын ачаалал, /тэрбум төгрөгөөр/.....	15
Дүрслэл 5. Инфляцын түвшин.....	15
Дүрслэл 6. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн түвшин	16
Дүрслэл 7. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй том зах худалдааны төвийн ХХОАТ-ын судалгаа.....	21
Дүрслэл 8. Татварын удирдлагын нэгдсэн систем болон татварын процесс үйл ажиллагааны хоорондын уялдаа.....	27
Дүрслэл 9. Эрсдэлийн түвшин болон зөвлөмжийн тоо	29
Дүрслэл 10. Мэдээлэл авах хүсэлтийн тоо, улсын тоо	30

Хавсралтын товьёг

Хавсралт 1. Татвар, төлбөр хураамжийн төрөл	35
Хавсралт 2. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-1	36
Хавсралт 3. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-2	37
Хавсралт 4. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-3	38
Хавсралт 5. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-2021-2022 он	39
Хавсралт 6. Холбогдох байгууллагын санал	40
Хавсралт 7. Саналын шийдвэрлэлт, түүнд өгсөн тайлбар	46

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

1. Аудит хийсэн үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан, УИХ-д танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Татварын шинэчлэлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нийцүүлж, боловсруулсан эсэх;
- Татварын хуулийн шинэчлэл нь төрийн санхүү, төсвийн бүрдүүлэлт болон нийгэм, эдийн засагт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

Аудитад Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Татварын ерөнхий хууль /2019/, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2019/, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /2019/, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2015/, Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай /2019/ болон татварын үйл ажиллагааг зохицуулж буй бусад хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, эдгээрийн харьяа газар, хэлтэс болон зарим байгууллагын 2019-2022 оны үйл ажиллагааг хамруулан, түүвэрчлэн шалгав.

Аудитын хязгаарлалт

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийн дагуу Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл сэдэвт аудитаар АМНАТ, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт сэдэвт аудитаар БНАТ-тэй холбоотой тусгайлсан аудитыг гүйцэтгэж, тайлан, дүгнэлт өгсөн тул аудитын хамрах хүрээг эдгээр сэдвийн хүрээнд хязгаарласан болно.

Хүндрэл бэрхшээл

Аудитад хамрагдсан 2019-2022 онд дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт болон татвар төлөгчдийн үйл ажиллагаанд үзүүлсэн сөрөг нөлөөллөөс үүдэж, татварын бодлого, хуулийн шинэчлэлийн хэрэгжилт, үр нөлөөг бодитоор хянаж, тооцох боломжийг алдагдуулж, аудитын дүн, чанарт нөлөөлөх эрсдэлтэй байсан.

3. Арга зүй

Гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-7:2020, Нийцлийн аудитын стандарт АДБОУС 4000, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгов. Үүнд:

- Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;
- Засгийн газрын Гурван тулгуурт хөгжлийн бодлого;
- Жилийн төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд тусгагдсан татварын бодлого;
- Татварын Ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Онцгой албан татварын тухай хууль;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль;
- Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай;
- Малын тоо толгойн албан татварын тухай;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Хувь хүний нууцын тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актууд

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ц.Бат-Өлзий хэрэгжүүлж, Мэдээллийн технологийн төвийн захирал Д.Энхтуяа, аудитын менежер Б.Батчимэг, ахлах аудитор Л.Мөнхцацрал, Э.Энхбаатар, Б.Эрдэнэбат, аудитор Б.Мөнхтуяа, Т.Нямсүрэн, М.Баяртогтох нар 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 20-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсад орчин цагийн татварын тогтолцоо 1990 онд бүрдэж, 1992 онд Албан татварын тухай хууль болон Татварын багц 5 хууль батлагдсан байна. УИХ-аас 2019 онд Татварын ерөнхий хууль, Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталснаар татварын шинэчлэл хэрэгжиж эхэлжээ.

Татварын үйл ажиллагаанд Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу “зайлшгүй байх”, “тодорхой байх”, “шударга байх” “үр ашигтай байх” зарчмыг мөрдлөг болгохоор заасан бөгөөд татвар нь нийгэмд дараах үндсэн 3 чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:


- ❖ Төрийн зардлыг санхүүжүүлэх буюу татварын санхүүгийн (фискаль) чиг үүрэг
- ❖ Эдийн засгийн жигд байнгын өсөлтөд нөлөөлж, боломж олгох буюу татварын тогтворжуулах үүрэг
- ❖ Орлого, эд хөрөнгийн шударга хуваарилалтад нөлөөлөх буюу дахин хуваарилалтын чиг үүрэг.

УИХ-аас Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөж эхэлсэн бөгөөд хуулийн үндсэн зорилго нь татварыг бүрэн хураах, татвар төлөгчдийг дэмжих, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, жижиг, дунд татвар төлөгчийн төлөх татварын хувь хэмжээг бууруулж, татварын бааз суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байна.

Татварын үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг:

“Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдэвт аудитаар Монгол Улсын Татварын үйл ажиллагаанд оролцогч тал, татварын шинэчлэлийн бодлогын орчныг дараах байдлаар тодорхойлов.

Дүрслэл 1. Татварын шинэчлэлийн орчин



Монгол Улсын Их Хурал: Засгийн газраас өргөн барьсан үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлого, тухайн жилийн төсөвт баримтлах татварын бодлогыг баталж байна.

Засгийн газар: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан УИХ-д өргөн барьж, тухайн жилийн төсвийг боловсруулахад баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг

тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх чиг үүрэг хүлээж байна.

Сангийн сайд: Засгийн газрын 2022 оны 76 дугаар тогтоолоор баталсан “Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилттэй холбоотойгоор Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын чиг үүргээс татварын “бодлого”-ын чиглэлийг салгаж, Татварын бодлогын газрыг шинээр бий болгосон байна.

Сангийн яамны харьяа Төв төрийн сан болон Аймаг нийслэлийн төрийн сан нь татварын орлогыг бүртгэх, улсын болон орон нутгийн төсөвт хуваарилах, тайлагнах үүргийг гүйцэтгэж байна.

Татварын ерөнхий газар: Татварын шинэчилсэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татварын харилцаанд оролцогчдыг мэдээллээр ханган, зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, татварыг бүрэн ногдуулах, хураах замаар улс, орон нутгийн төсвийн татварын орлогыг бүрдүүлэх, харьяа нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гаалийн ерөнхий газар: Гаалийн онцгой албан татварын болон бусад орлогын ногдуулалт, барагдуулалт, татвар хорогдуулан тооцох, суутган тооцох, буцаан олгох, хойшлуулах, тарифын хөнгөлөлт, татварын чөлөөлөлтийн зохицуулалтын үйл ажиллагааг ил тод, цахим хяналтад шилжүүлэх, импортын барааны гаалийн болон бусад татварын чөлөөлөлт, гаалийн нутаг дэвсгэрт татвараас чөлөөлөгдөн түр хугацаагаар орох барааны гаалийн бүрдүүлэлтийн хэрэгжилтийг хянах, заавар зөвлөмжөөр хангах зэрэг “татвар”-тай холбоотой хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ 1. ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГОД ТУЛГУУРЛАН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЭДИЙ Ч ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Монгол Улсад татварын тогтолцоо бүрдсэн 1990 оноос хойших хугацаанд эдийн засгийн нөхцөл байдал, цаг үеийн шаардлагаас хамаарч Засгийн газраас татварын бодлого, татварын шинэчлэлийг хэд хэдэн үе шаттай хэрэгжүүлж иржээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “*бизнесийг дэмжсэн татварын хоёр дахь үе шатны шинэчлэлийг хийх*” зорилтын хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Жижиг хэмжээний ажил, үйлчилгээ эрхлэгч этгээдийн орлогын албан татварын тухай, Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэрэгжүүлэх” зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн Макро эдийн засгийг тогтворжуулах бодлогын хүрээнд:

- ❖ Байнгын болон түр ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжийг татвар, зээлийн бодлогоор дэмжих;
- ❖ Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, мэргэжлийн хяналт, татвар, нийгмийн даатгал, хууль хяналтын байгууллагын давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах гэсэн зорилт тавьсан нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн ААНОАТТХ-д туссанаар биеллээ олсон байна.

1.1 Татварын шинэчлэлд баримтлах бодлогод оролцогч талуудын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийн уялдааг хангах, хэрэгжилтийг хянаж, нэгтгэн дүгнэх шаардлагатай байна.

Дүрслэл 2. Татварын шинэчлэлийн бодлогын баримт бичиг



1.1.1 Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан Гурван тулгуурт хөгжлийн бодлого болон эдийн засгийг дэмжих санхүү, төсвийн бодлогын хүрээнд татварын шинэчлэлийг төлөвлөж хэрэгжүүлжээ.

1.1.2 Татварын шинэчлэл нь татварыг бүрэн хураах, татвар төлөгчдийг дэмжих зорилт, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, жижиг, дунд татвар төлөгчийн төлөх татварын хувь

хэмжээг бууруулж, татварын бааз суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байна.

1.1.3 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан татварын үйл ажиллагааг зохицуулсан 8 арга хэмжээнээс 7 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 87.5 хувьтай байна.

1.1.4 Харин “хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн хөтөлбөрийг хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан хэрэгжих хугацааг хойшлуулсан байна.

1.1.5 Засгийн газрын 2018 оны 42 дугаарт тогтоолоор Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (2015-2030), Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын

2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Хөгжлийн зам хөтөлбөртэй уялдуулж “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталсан байна.

1.1.6 Гурван тулгуурт хөгжлийн бодлогын зорилгыг шударга ёс, сахилга хариуцлагатай, тогтвортой төрийн тогтолцоог бэхжүүлж, нэгдсэн бодлогоор эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлж, иргэдийнхээ амьдралын түвшнийг сайжруулахад оршино гэж тодорхойлжээ.

1.1.7 Уг бодлогоор 27 зорилтын хүрээнд 149 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс, 79 арга хэмжээ “үр дүнтэй”, 48 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувь”, 21 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй гэж Үндэсний хөгжлийн газар (хуучин нэрээр)-аас 2019 он, 2020 онуудыг хамруулж үнэлсэн бөгөөд бодлогыг хэрэгжүүлэх хугацаа дууссан байна.

1.1.8 Аудитаар үнэлгээг дахин нягтлахад “ажлын байр олноор бий болгоход татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх” зорилтын хэрэгжилт, үр дүн тодорхойгүй байна.

1.1.9 Татварын шинэчлэл болон тухайн жилийн төсөвт баримтлах “татварын бодлого”-ыг Монгол Улсын 2019, 2020, 2021, 2022 оны Төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд тусгаж, УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан боловч хэрэгжүүлэгч байгууллага, хүрэх үр дүнг тодорхой тусгаагүй байна.

1.1.10 ТЕГ Татварын ерөнхий хуулийн шинэчлэлийн хүрээнд 2019-2022 он хүртэл хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн 89 зорилт, арга хэмжээнээс 88 арга хэмжээг хэрэгжүүлж, 1 арга хэмжээг 2023 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

1.1.11 Татварын үйл ажиллагаанд мөрдөх дунд хугацааны стратеги болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Сангийн яам болон Татварын ерөнхий газар тус тус баталсан боловч хэрэгжүүлэх арга хэмжээ уялдаа холбоогүй, хугацаа харилцан адилгүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1¹, 54 дүгээр зүйлийн 54.1²-д заасантай нийцэхгүй байна.

1.1.12 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-д “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг уялдуулан батлах” гэж заасны дагуу бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах, үнэлж дүгнэх шаардлагатай байна.

1.2 Татварын шинэчлэлийн хүрээнд багц хуулиудыг шинэчлэн баталж, холбогдох 28 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан боловч зарим татварын хуулийг шинээр боловсруулах, татварын хуулийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2.1 Татварын эрх зүйн шинэчлэлд татварын хувь хэмжээ, татварын тайлагналын тоог бууруулж хялбаршуулах, татвар төлөгч, татварын албаны эрх үүргийг тэнцвэржүүлэх, татварын багц хуульд олон улсын татварын харилцаа, үнэ шилжилтийн асуудлуудыг тусгажээ.

1.2.2 Татварын хуулийг шинэчлэх гол үндэслэл нь:

- ❖ 2006 оноос хойш эдийн засаг, бизнесийн харилцаа өргөжин төрөлжиж, даяарчлагдсан нарийн төвөгтэй, техник технологийн хурдацтай өөрчлөлтийн орчинд явагдах болсон;
- ❖ Манай улсад үйл ажиллагаагаа явуулж буй Дэлхийн түвшний үндэстэн дамнасан корпорацууд улс хооронд үнэ шилжилт хийн татвараас зайлсхийх эрсдэл үүсэж татварын маргаан, үл ойлголцол бий болсон;
- ❖ Татварын эрх зүйн орчин ил тод биш, мэдээлэл харилцан солилцдоггүй эрсдэл тулгарсан.

¹ 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

² 54.1.Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

1.2.3 Эрх зүйн шинэчлэлтэй холбогдуулан Сангийн яам болон Татварын ерөнхий газар хамтран Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5³, 38 дугаар зүйлд⁴ заасны дагуу 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 32 хоногийн хугацаанд хуулийн шинэчилсэн төслийн хэлэлцүүлгийг цахимаар болон танхимаар өргөн хүрээтэй зохион байгуулж, 5,549 санал иргэд, аж ахуйн нэгжээс хүлээн авсан байна.

1.2.4 Нийт ирүүлсэн саналаас 1,891 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэж, 1,783 саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгаж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын тайлагнал, хувь хэмжээ, хялбаршуулсан горим болон татварын ерөнхий орчинтой холбоотой 1,875 сэтгэгдэл, асуултад тухай бүр хариу өгч ажиллажээ.

1.2.5 Татварын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд иргэд олон нийт, бизнес эрхлэгчдийн төлөөлөл, хөрөнгө оруулагч, олон улсын байгууллагын төлөөлөл, ТББ-ын төлөөллийн саналыг авч хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцэж байна.

1.2.6 УИХ-аас 2019 онд ТЭХ-ийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрджээ. ТЭХ-ийн шинэчилсэн найруулгыг дагалдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг тус тус шинэчлэн баталж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд болон Зөрчлийн тухай хууль, Дампуурлын тухай хууль, Банкны тухай хууль зэрэг 28 төрөлжсөн хуулийн татварын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.2.7 Татварын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах үүднээс Сангийн сайдын баталсан 26 журам, Татварын ерөнхий газрын баталсан нийтээр дагаж мөрдөх 51 захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулж мөрдөж байна.

1.2.8 Гэвч Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 2008 онд батлагдсан бөгөөд татварын хуулийн шинэчлэлтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийг тусгаагүй байна. Тус хуулийг шинэчлэх дараах зайлшгүй шаардлага тулгарч байна. Үүнд:

- ❖ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- ❖ Монгол Улсын 2017 онд нэгдэн орсон “Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах зохицуулалтыг тусгах;
- ❖ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандах судалгаа, гаалийн харилцаанд оролцогч, гаалийн албан хаагчдын дунд явуулсан санал, асуулгаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шаардлагатай байгааг илэрхийлсэн байна.

1.2.9 Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль, Монгол улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулиудыг ТЭХ-ийн шинэчлэлтэй холбогдуулан өөрчлөөгүй, Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, Нохойны албан татвар, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн албан татварын тухай хуулийг шинээр боловсруулахаар хуульд тусгасан байна.

1.2.10 Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу Татварын ерөнхий хууль болон холбогдох хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг болон сөрөг нөлөөг үнэлж, үр дүнг хуульд тусгах боломж байна.

³ 8.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах

⁴ 38 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах

БҮЛЭГ 2. ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАГДАХ ЭРХ САЙЖИРЧ ТӨСВИЙН ОРЛОГО ӨССӨН БОЛОВЧ ТАТВАРЫН АЧААЛАЛ НЭМЭГДСЭН БАЙНА.

2.1 Нэгдсэн төсвийн нийт орлогын 70 гаруй хувийг татварын орлого бүрдүүлж, 2019-2022 онд 5,050.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.1.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогын 60.2-74.6 хувь нь татварын орлогоос бүрдэж байна. Улсын төсвийн нийт орлогод эзлэх татварын орлого 2013-2016 онд буурч, 2017-2022 онд өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Төсөвт үзүүлэх татварын орлогын нөлөө, /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нийт орлого тусламжийн дүн	5,958.9	6,336.4	5,867.8	6,064.2	8,294.3	10,425.3	12,060.0	10,956.2	14,340.8	18,521.6
Татварын орлого	3,920.4	3,875.9	3,680.1	3,653.5	5,677.2	7,385.0	8,764.8	7,745.7	10,374.0	13,815.4
Улсын төсвийн нийт орлогод эзлэх татварын орлогын хувь	65.8	61.2	62.7	60.2	68.4	70.8	72.7	70.7	72.3	74.6

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1.2 Татварын орлогын хэмжээ сүүлийн 10 жилд 3,920.4 тэрбум төгрөгөөс 13,815.4 тэрбум төгрөгт хүрч 3.5 дахин өссөн байна. Татварын шинэчлэл хийгдсэнээр татварын орлогод эзлэх онцгой албан татварын хувь 3.7 нэгжээр буурч, бусад татвар, төлбөр хураамжийн хувь 3.7 нэгжээр өссөнөөс өөр татварын төрлүүдийн хооронд орлогын хувийн жингийн өөрчлөлтүүд гараагүй байна.


Хүснэгт 2. Татварын орлогын бүрэлдэхүүн, /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он		2022 он		2019/2022 өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Орлогын албан татвар	2,596.2	29.6	2,231.2	28.8	3,493.0	33.7	4,064.8	29.4	1,468.6	-0.2
Хөрөнгийн албан татвар	154.4	1.8	154.9	2.0	201.1	1.9	237.6	1.7	83.2	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,486.3	28.4	2,209.0	28.5	2,837.7	27.4	3,946.2	28.6	1,459.9	0.2
Онцгой албан татвар	863.4	9.9	776.9	10.0	827.0	8.0	847.8	6.1	-15.6	-3.7
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	16.4	0.2	17.1	0.2	16.6	0.2	19.4	0.1	3.0	0.0
Гаалийн албан татвар	790.1	9.0	740.7	9.6	938.9	9.1	1,255.5	9.1	465.4	0.1
Бусад татвар, төлбөр, хураамж	1,858.0	21.2	1,616.0	20.9	2,059.7	19.9	3,444.2	24.9	1,586.2	3.7
НИЙТ ОРЛОГО	8,764.8	100.0	7,745.7	100.0	10,374.0	100.0	13,815.4	100.0	5,050.6	0.0

Эх сурвалж: Үндэсний аудитын газар 2023

2.1.3 Татварын орлогын 65.0 гаруй хувийг Татварын алба, 35.0 орчим хувийг Гаалийн байгууллага төвлөрүүлэн бүрдүүлж байна.

Дүрслэл 3. Татварын орлогын бүрдүүлэлт, /хувиар/




Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2 Татварын ачаалал болон инфляцын түвшин өсөж байгаа нь татварын шинэчлэлийн “эдийн засгийг сэргээх, иргэдийн амьдралыг дэмжих” бодлогын үр нөлөөг сулруулж байна.

2.2.1 Улсын төсвийн орлогод эзлэх татварын орлого нэмэгдэхийн сацуу 2016-2022 онуудад дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын хэмжээ буюу татварын нийт ачааллын хэмжээ 8.5 нэгжээр, татварын шинэчлэл хэрэгжиж эхлэхээс өмнөх 2019 онтой харьцуулахад 2.6 нэгжээр тус тус өсжээ.


Дүрслэл 4. ДНБ-д эзлэх татварын ачаалал, /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2.2 Монгол Улсын татварын ачаалал нь 29.2 хувьд хүрсэн нь олон улсын татварын ачааллын дундаж хэмжээнээс /20.8 хувь/ 8.4 нэгжээр, хөгжиж буй Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийн зарим орнуудын дундаж /21 хувь/-аас 8.2 нэгжээр тус тус өндөр байна.

Дүрслэл 5. Инфляцын түвшин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2.2.3 Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хөл хорио, хилийн хязгаарлалт тавигдсанаар тээвэр логистикийн хүндрэл үүсэж, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт саарах, импортын түүхий эд, бараа материалын хомсдол бий болох, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалж инфляцын түвшин 2022 оны эцсийн байдлаар 10.9 нэгжээр өсөж 13.2 хувьд хүрсэн байна.

2.2.4 Засгийн газрын Гурван тулгуурт хөгжлийн бодлогын “ажлын байр олноор бий болгоход татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх” зорилтын хэрэгжилтийг хөдөлмөр эрхлэлтийн түвшинтэй харьцуулж үзэхэд 2019-2022 онд 0.3 хувиар өсөж, 54.7 хувьд хүрсэн байна.

Дүрслэл 6. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн түвшин



2.2.5 Дээрх бодлогын хүрээнд Засгийн газраас 2016-2020 онд ажилгүйдлийн түвшнийг 3 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн боловч 7 хувьтай гарч, зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2.3 Мэдээлэл технологийн шинэчлэлийг татварын хуулийн шинэчлэлтэй уялдуулж зохион байгуулснаар, татварын байгууллагын мэдээлэл авах эрх сайжирч, далд эдийн засгийн хэмжээ буурсан байна.

2.3.1 Далд эдийн засгийн бүлэгт хууль тогтоомж мөрдүүлэх үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд нуугдмал үйлдвэрлэл, хууль бус үйлдвэрлэл, албан бус секторын үйлдвэрлэл, өрхийн хэрэглээний үйлдвэрлэл болон хувь хүмүүсийн татварын үүрэг хариуцлагаас зайлсхийх далд эдийн засгийн зан хандлагыг тодорхойлж, соён гэгээрүүлэх, цахим төлбөрийн баримтын систем, НӨАТ-ын урамшууллаар дамжуулан далд эдийн засгийн хэмжээг бууруулах бодлогыг хэрэгжүүлж ажилласан байна.

2.3.2 ҮСХ-оос гаргасан далд эдийн засгийг хэмжих үечилсэн судалгаагаар Монгол Улсын далд эдийн засгийн хэмжээ 2016-2018 онд 3.8 нэгжээр, 2019-2021 онд 1.5 нэгжээр буурч 4.8 хувьд хүрсэн бөгөөд 2022 оны статистикийн судалгааны үр дүн гараагүй байна.

Хүснэгт 3. Далд эдийн засгийн хэмжээ

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
ДНБ* (тэрбум төгрөг)	23,931.3	28,010.7	32,582.6	37,839.2	37,453.3	43,555.5
Далд эдийн засаг (тэрбум төгрөг)	3,154.5	2,525.8	3,064.0	2,395.6	1,878.9	2,078.7
ДНБ-д далд эдийн засгийн эзлэх хувь	13.2	9.0	9.4	6.3	5.0	4.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2.3.3 Төрийн байгууллагуудаас мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, и-баримтын цахим үйл ажиллагааг үе шаттайгаар сайжруулж, хиймэл оюун ухаан ашиглан эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлснээр ДНБ-д эзлэх далд эдийн засгийн хэмжээ сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна.

2.3.4 Татварын бодлогын шинэчлэлийн хүрээнд зарим татварын хувь хэмжээг шатлалтайгаар бууруулах арга хэмжээ авсан байна. Тухайлбал оюуны өмчийн эрх борлуулсны орлогын албан татварыг 25 хувиар бууруулж 5 хувь, Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогоос авах татварыг 5-15 хувиар бууруулж 5 хувь, төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлогын албан татварыг 20 хувиар бууруулж 10 хувь байхаар тус тус зохицуулжээ. Мөн 300 сая төгрөг хүртэлх татвар ногдох орлоготой ААН, 50 сая төгрөг хүртэлх татвар ногдох орлоготой иргэнд тус тус 1 хувиар татвар ногдуулж, жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлого бүхий ААН-ын төлсөн татварын 90 хувийг буцаан олгож эхэлсэн байна.

2.3.5 Бүртгэлтэй татвар төлөгчдийн тоо татварын шинэчлэл хийгдэхээс өмнөх 2019 онтой харьцуулахад иргэн 1.1 дахин өсөж 2,092.0 мянга, ААН 1.2 дахиж өсөж 244.4 мянга, НӨАТ төлөгч 1.6 дахин өсөж 53.6 мянгад тус тус хүрсэн байна.

2.3.6 УБЕГ-т хуулийн этгээдийн үндсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр ХУР цахим системээр дамжуулан татвар төлөгчийн мэдээлэл Татварын ерөнхий газарт бүртгэгдэж байна. **Хүснэгт 4. Татвар төлөгчийн бүртгэл**

Д/д	Татвар төлөгчийн тоо	2019 он	2020 он	2021 он	2022 он	<u>2019</u> 2022 өсөлт
1	Иргэн	1,935,356	2,039,153	2,071,622	2,092,004	1.1
2	ААН	204,514	218,926	226,505	244,379	1.2
3	НӨАТ төлөгч	32,588	37,831	47,043	53,625	1.6

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

2.3.7 АТБӨЯХ, үл хөдлөх хөрөнгө, газар, галт зэвсэг зэрэгт хөрөнгийн албан татварыг ногдуулдаг бөгөөд хөрөнгийн тоо 2019-2022 онд дунджаар 1.8 дахин өссөн байна.

Хүснэгт 5. Татвар ногдуулах хөрөнгийн тоо

Д/д	Хөрөнгийн төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	<u>2019</u> 2022 өсөлт
1	АТБӨЯХ-ийн тоо	907,754	1,040,405	1,107,766	1,161,927	1.3
2	Үл хөдлөх хөрөнгийн тоо	39,376	45,656	55,833	80,465	2.0
3	Газрын төлбөрийн ногдуулах хөрөнгийн тоо	-	484,689	554,276	597,739	-
4	Галт зэвсгийн тоо	25,231	48,852	47,301	52,872	2.1

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

2.3.8 Татварын байгууллагад бүртгэлтэй ААН тоо 2019 оноос 61.0 мянгаар өссөн боловч татварын тайлан ирүүлж буй ирц 71.5 хувиас хэтрэхгүй, үүнээс “Х” тайлан гаргаж буй ААН-ын тоо 20.7 мянгаар нэмэгдсэн нь нийт татвар төлөгчдийн 32.2 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн ирцийн мэдээ

Он	Ирүүлбэл зохих	Ирүүлсэн	Хувь	Х тайлан	Ногдолтой тайлангийн тоо	Ногдлын дүн /тэрбум төгрөг/
2019 он	157,930	112,987	71.5	49,826	46,103	1,776.8
2020 он	195,623	135,658	69.3	69,169	35,251	1,304.1
2021 он	209,987	148,812	70.9	75,208	46,424	1,667.4
2022 он	218,965	155,450	71.0	70,561	52,106	2,817.2

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

2.3.9 ААНОАТ болон ХХОАТ-ын тайланг 8 улирал дараалан гаргаагүй, “Х” тайлан ирүүлсэн 38,210 аж ахуйн нэгжийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.15-т заасныг үндэслэн Улсын бүртгэлээс хассан байна.

⁵ “Санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага өөрийн цахим хуудсаар нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр санал, гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна”

БҮЛЭГ 3. ТАТВАРЫН ОРЛОГЫГ ХУВААРИЛАХ, БҮРТГЭЖ ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1 Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд татвар төлөгчдөд таатай нөхцөлийг бий болгосон хэдий ч зарим тодорхойгүй зохицуулалтуудыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна.

3.1.1 Шинэчлэн найруулсан ТЕХ-аар 13 албан татвар, 14 төлбөр, 3 хураамж, нийт 30 нэр төрлийн татварыг ногдуулж, төвлөрүүлэхээр зааснаас 8 төрлийн татварын орлогыг улсын төсөвт, 15 төрлийн татварын орлогыг орон нутгийн төсөвт, 4 төрлийн татварын болон татварын бус орлогыг улс болон орон нутгийн төсөвт хувь тооцон хуваарилж байна.

3.1.2 Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, Нохойны албан татвар, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн албан татварын тухай хуулийг шинээр боловсруулахаар ТЕХ-д тусгасан байна.

3.1.3 Шинэчлэн батлагдсан ААНОАТ-ын хуулиар өмнө нь хэрэглэж байсан татвар ногдох орлогын 2 шатлалт суурийг татвар төлөгчдийг борлуулалтын орлогоос шалтгаалан том, дунд, жижиг, бичил гэсэн 4 сегментэд ангилан татвар ногдуулах 5 шатлалт суурь болгон ангилан тогтоосон байна.

Хүснэгт 7. ААНОАТ-ын хуулийн суурьд орсон өөрчлөлт

2019 онд		2020 оноос хойш				
Татварын суурь	Хувь хэмжээ	Ангилал	Орлого	Татварын суурь	Хувь хэмжээ	Тайлагнах хугацаа /жилд/
0-3 тэрбум төгрөгийн татвар ногдох орлого	10%	Том сегмент	Татвар ногдуулах	6 тэрбум төгрөг	10%-25%	4
3 тэрбум төгрөгөөс дээш ногдох орлого	10%-25%	Дунд сегмент	Нийт борлуулалтын орлого Татвар ногдуулах	1.5-6 тэрбум төгрөг	10%	2
Жилд 4 удаа тайлагнана		Жижиг сегмент	Татвар ногдох	300 сая-1.5 тэрбум төгрөг	10%-9%	2
			Цэвэр борлуулалтын орлого	50 сая-300 сая төгрөг	1%	2
		Бичил сегмент	Нийт борлуулалтын орлого	50 сая төгрөгөөс доош	1%	1

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

3.1.4 ТЕХ-ийн шинэчлэлээр орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татварын төрөл хасагдаж, Малын тоо толгойн албан татвар, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр гэсэн 2 төрөл нэмэгдсэн байна.

3.1.5 Орон нутагт ажлын байрыг дэмжих зорилгоор нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алсдагдсан аймаг, суманд 90 хувиар татвараас хөнгөлөхөөр хуульчилсан байна.

3.1.6 ААНОАТТХ-ийн шинэчилсэн зохицуулалтын дагуу алслагдсан бүсийн 49 татвар төлөгчид 2.3 тэрбум төгрөгийг 2020 онд, 2021 онд 57 татвар төлөгчид 3.3 тэрбум төгрөг, 2022 онд 85 татвар төлөгчид 2.1 тэрбум төгрөг, нийт 191 татвар төлөгчид 7.7 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлж, буцаан олгосон байна.

3.1.7 Түүнчлэн, жилийн 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд татвар ногдуулах орлогын 1 хувиар татвар төлөх, 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн төлсөн орлогын татварын 90 хувийг буцаан олгох зэргээр жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан татварын дэмжлэг үзүүлжээ. Энэ зохицуулалтын хүрээнд 2020 онд 297 татвар төлөгч 2.0 тэрбум төгрөг, 2021 онд 2491 татвар төлөгч 36.6 тэрбум төгрөг, 2022 онд 3,933 татвар төлөгч 59.2 тэрбум төгрөг, нийт 6,721 татвар төлөгчид 97.8 тэрбум төгрөгийг буцаан олгосон байна.

3.1.8 ААНОАТ төлөгчдийн татвараа үнэн зөв тайлагнадаг сэдлийг бий болгохын тулд бичил болон жижиг сегментийн татвар төлөгч жилд 1 удаа буюу жилийн эцсээр, дунд сегментийн татвар төлөгч жилд 2 удаа буюу хагас, бүтэн жилээр, том сегментийн татвар төлөгч буюу 1 жилд ногдох борлуулалтын орлого нь 6.0 тэрбум төгрөгөөс дээш бол улирал тутам орлогын тайлангаа ТЕГ-т илгээдэг байхаар шинэчлэн зохицуулсан байна.

3.1.9 Хуулийн шинэчилсэн зохицуулалтын хүрээнд 2020 онд 75,995, 2021 онд 87,594, 2022 онд 78,460 иргэн хялбаршуулсан горимоор татварын тайлангаа илгээсэн байна.

3.1.10 Гадаадын иргэн, харьяатын газрын 2019-2022 онд хураасан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 10 дугаар зүйлийн 10.6-т заасан Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд оршин суух зөвшөөрөл олгох, виз сунгах, визний нөхцөлийг өөрчлөх, байнгын болон түр оршин суух зөвшөөрөл олгох үйлчилгээний 5.1 тэрбум төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.9-дэх заалттай нийцэхгүй байна.

3.1.11 ТЕГ нь 2021 онд “Оюу толгой” ХХК-аас 1,014.4 тэрбум төгрөгийн татварын актын төлбөрийг үл маргах журмаар төвлөрүүлснээс, хүү, торгууль алдангид ногдох 356.7 тэрбум төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт хуваарилаагүй байна.

3.1.12 АТБӨЯХАТХ 1992 онд батлагдсанаас хойш 7 удаа өөрчлөлт орсон бөгөөд хуулийн 6 дугаар зүйлийн 1-т “Улсын бүртгэлд байгаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийг ашиглаж байгаа эсэхийг үл харгалзан албан татвар ногдуулна” гэж зохицуулсан байдаг.

3.1.13 АТБӨЯХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3-д заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон татварын хувь 14-33, тээврийн хэрэгслээс хамаарч тариф 6.0 мянга-1,000.0 мянган төгрөг байна.

3.1.14 Зам, тээврийн хөгжлийн сайдын А/222 тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын дагуу 5 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй 150,996 тээврийн хэрэгслийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр улсын бүртгэлээс хассан бөгөөд тэдгээрт ногдуулсан өмнөх онуудын АТБӨЯХАТ-ын 31.1 тэрбум төгрөг, автын агаарын бохирдлын төлбөр 2.5 тэрбум төгрөг, нийт 33.6 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өрийг хураахад хүндрэл үүсэх төлөвтэй байна.

3.1.15 ҮХЭХАТХ-д 2000 оноос хойш 9 удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүнийг дагалдуулан баталсан Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталснаар 2022 оноос эхлэн гурав ба түүнээс дээш орон сууц өмчилдөг иргэд хоёр орон сууцаа өөрсдөө сонгон татвараас чөлөөлүүлэх, гурав дахь орон сууцанд 0.6-2 хувийн албан татвар төлөх зохицуулалт хийсэн.

3.1.16 Ипотекийн зээлийн хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн орон сууц өмчлөгч иргэд, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ бүхий дуусаагүй барилга, байгууламж, албан хаагчдадаа эзэмшүүлж байгаа боловч өмчлөл нь байгууллагуудын нэр дээр байгаа 3 дахь орон сууцнаас авах албан татварыг хэрхэн шийдвэрлэх нь эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй байна.

3.2 Татварын орлогоос хуульд заасан хэмжээгээр орон нутгийн төсөвт хуваарилаагүй, орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуулиар олгогдсон эрхийн хүрээнд татварын хувь хэмжээг харилцан адилгүй тогтоож байна.

3.2.1 Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ААНОАТ-ын орлогыг 100 хувь улсын төсөвт төвлөрүүлдэг байсныг 40 хувийг орон нутгийн төсөвт хуваарилах зохицуулалтыг 2022 оноос хэрэгжүүлж байна. ААНОАТ-ын орлогыг хувь тооцон улсын болон орон нутгийн төсөвт хуваарилах үйл ажиллагааг зохицуулсан журам нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай бүрэн нийцэхгүй байна. Төсвийн тухай хуулийн 23.6⁶, 23.6.10⁷-т зааснаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг орон нутгийн төсөвт хуваарилахаар тусгасныг Сангийн сайдын 2022 оны А7 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт

⁶ Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ

⁷ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь

тавих журам”-ын 3.8⁸-д тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний дүнгээр олгох бөгөөд давсан орлогоос хуваарилахгүй байхаар нарийвчлан зохицуулсан байна.

3.2.2 ААНОАТ-аас орон нутагт хуваарилах орлогыг 705.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 443.1 тэрбум төгрөгийг хуваарилж, 262.2 тэрбум төгрөгийг дутуу олгосон байна. Хүснэгт 8. ААНОАТ-ын хуваарилалт, /тэрбум төгрөгөөр/

Төсвийн ангилал, татварын төрлөөр	2022 он		
	Төлөв	Гүйц	Хувь
Татварын нийт орлого	8,016.2	9,332.9	116%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,524.4	2,135.2	140%
ААНОАТ-ын 40 хувь	609.8	854.1	56%
Үүнээс хуваарилсан:			
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /Нийслэлийн төсөв/	240.4	240.4	100%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /Аймгийн төсөв/	465.0	202.7	44%
НИЙТ ХУВААРИЛСАН ДҮН	705.3	443.1	63%
ХУВААРИЛАЛТЫН ЗӨРҮҮ	(95.6)	411.0	(430%)

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

3.2.3 Сангийн яамнаас тайлант оны санхүүжилтийн эх үүсвэр дутагдсан аймгуудад ААНОАТ-ын 2023 онд хуваарилах орлогоос 133.4 тэрбум төгрөгийг урьдчилан олгосон байна. Мөн Дархан-Уул, Өмнөговь, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад ААНОАТ-аас хуваарилах орлогыг 7.7-16.7 хувиар олгосон байна.

Хүснэгт 9. Орон нутгийн төсвийн орлого, /тэрбум төгрөгөөр/

№	Аймгийн нэрс	Орлого				№	Аймгийн нэрс	Орлого			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
1	Архангай	0.5	0.3	0.2	60.0	13	Сэлэнгэ	19.3	6.2	13.1	32.1
2	Баян-Өлгий	0.6	0.1	0.5	16.7	14	Төв	2.4	0.6	1.8	25.0
3	Баянхонгор	0.7	0.1	0.6	14.3	15	Увс	0.8	0.2	0.6	25.0
4	Булган	0.7	0.6	0.1	85.7	16	Ховд	4.3	10.5	-6.2	244.2
5	Говь-Алтай	0.5	0.1	0.4	20.0	17	Хөвсгөл	1.2	0.3	0.9	25.0
6	Дорноговь	6.6	12	-5.4	181.8	18	Хэнтий	8.4	4.7	3.7	56.0
7	Дорнод	14	8.7	5.3	62.1	19	Дархан-Уул	5.2	0.4	4.8	7.7
8	Дундговь	0.4	0.1	0.3	25.0	20	Орхон	68.2	71.9	-3.7	105.4
9	Завхан	6.8	4.9	1.9	72.1	21	Говьсүмбэр	0.2	0.2	0	100.0
10	Өвөрхангай	1	0.3	0.7	30.0	22	Улаанбаатар	240.4	240.4	-	100.0
11	Өмнөговь	313.6	44.5	269.1	14.2	ДҮН		703.4	420.9	282.5	59.8
12	Сүхбаатар	7.6	13.8	-6.2	181.6						

Эх сурвалж: Үндэсний аудитын газар 2023 он

3.2.4 ТЕХ-ийн 8 дугаар зүйлд Татварын хувь хэмжээг УИХ, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, хотын Зөвлөл тогтоосон хязгаарт багтаан тогтоож болно гэж заасан байна. Үүнд:

- ❖ Хувь хүний орлогын албан татвар;
- ❖ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;
- ❖ Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;
- ❖ Нийслэл хотын албан татвар;
- ❖ Нохойны албан татвар;
- ❖ Байгалийн ургамал ашигласны төлбөр;
- ❖ Рашаан ашигласны төлбөр;
- ❖ Ан амьтны нөөц ашигласны төлбөр;
- ❖ Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

Харин Малын тоо толгойн албан татвар, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг УИХ-аас тусгайлан эрх олгогдсон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл тогтоохоор зохицуулсан байна.

3.2.5 Аймаг, нийслэлийн ИТХ-аас үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хэмжээг 0.6-2 хувиар, малын тоо толгойд ногдуулах татварын тарифыг 6 сумд 0 төгрөг, бусад сумдад 250.0-2,000.0 төгрөгөөр харилцан адилгүй тогтоосон байна.

⁸ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын тухайн жилийн төсвийн батлагдсан төлөвлөгөөний дүнгээс давсан бол аймаг, нийслэлийн төсөвт хуваарилахгүй.

3.2.6 Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр хуулиар олгогдсон эрх, хэмжээндээ татварын хувь, тарифыг ялгамжтай байдлаар тогтоож байна.

3.2.7 Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.39-т татварын тайлангаа малчид өөрсдөө тайлагнаж, татварын удирдлагын мэдээллийн системд илгээдэг байхаар зохицуулсан нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

3.2.8 Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн татварын орлогын дүн Сангийн яамны Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн орлогын дүнгээс зөрүүтэй байгаа нь татварын удирдлагын нэгдсэн системд орлогыг бодит цагийн горимоор шууд, Төрийн санд ажлын бус цагаар хийгдсэн орлогыг дараагийн өдөрт бүртгэж буй МТ-ын хөгжүүлэлтийн ялгаатай байдлаас үүдсэн байна.

Хүснэгт 10. МУНТГ-ийн тайлан, ТБМНС-ийн татварын орлого, /тэрбум төгрөгөөр/

Эх сурвалж	Үзүүлэлт	2019 он			2020 он			2021 он			2022 он		
		Төлөв	Гүйц	Хувь	Төлөв	Гүйц	Хувь	Төлөв	Гүйц	Хувь	Төлөв	Гүйц	Хувь
ТБМНС	Татварын орлого: Үүнээс	5,388.8	5,791.0	107.5	5,562.4	5,183.3	93.2	7,174.6	7,175.5	100.0	8,016.2	9,332.9	116.4
	Улсын төсөв	4,117.0	4,509.0	109.5	4,258.8	3,920.8	92.1	5,556.9	5,478.6	98.6	5,395.5	6,895.5	127.8
	Орон нутаг төсөв	1,271.8	1,282.0	100.8	1,303.6	1,262.5	96.8	1,617.7	1,696.9	104.9	2,620.7	2,437.4	93.0
МУНТГ-ийн тайлан	Татварын орлого: Үүнээс	5,369.4	5,798.2	108.0	5,546.5	5,156.3	93.0	7,128.4	7,131.2	100.0	7,886.7	9,257.9	117.4
	Татварын ерөнхий газар	4,117.0	4,509.0	109.5	4,258.8	3,920.8	92.1	5,556.9	5,478.6	98.6	5,395.5	6,895.5	127.8
	Орон нутгийн төсөв	1,252.4	1,289.2	102.9	1,287.6	1,235.5	95.9	1,571.5	1,652.6	105.2	2,491.2	2,362.4	94.8
Зөрүү		19.4	(7.2)		16.0	27.0		46.1	44.3		129.5	75.0	

Эх сурвалж: Үндэсний аудитын газар 2023 он


3.3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн татварын шинэчлэл хийхээс өмнөх 2019 онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн боловч хувиараа бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, татвар ногдуулалт, хураалт, цахим и-баримт олголт хангалтгүй байна.

3.3.1 ХХОАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-т татвар төлөгчийн дараах орлогод татвар ногдуулахаар тодорхойлсон байна. Үүнд,

- Цалин, хөдөлмөрийн хөлс;
- Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;
- Үйл ажиллагааны орлого;
- Хөрөнгийн орлого; хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
- Шууд бус орлого;
- Бусад орлого;

3.3.2 Хуулийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор нийслэлийн 9 дүүргийн 26 худалдааны төвд худалдаа эрхлэгчдийг хамруулж, ХХОАТ-ын тайлагналын байдалд дүн шинжилгээ хийхэд худалдаа эрхлэгчдийн тоо 2019 – 2022 онд 2716-аар нэмэгдэж 9912 болсон байна.

Дүрслэл 7. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй том зах худалдааны төвийн ХХОАТ-ын судалгаа



Эх сурвалж: Үндэсний аудитын газар 2023 он.

⁹ 7.3 Албан татвар төлөгч албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, тухайн татварын жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ.

3.3.3 Худалдаа эрхлэгчийн тоо өссөн боловч ХХОАТ-ын тайлангаа татварын мэдээллийн системд тайлагнаж буй ирц 8.8 – 24.1 хувь буюу хангалтгүй түвшинд байгаагаас ногдуулсан болон төлсөн татварын орлогын хооронд жил бүр 0.7– 1.1 тэрбум төгрөгийн илүү төлөлт үүсэж, урьдчилж төлсөн татварын орлогоор бүртгэж байна.

3.3.4 Мөн орлогын хэмжээг нарийн тооцох боломжгүй эрсдэлт бүлгийн буюу алт тушаагч, өмгөөлөл, нотариатын үйлчилгээ болон бусад төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа нийт 11,148 иргэн татварын албанд татвар төлөгчөөр бүртгэлтэй байна.

3.3.5 ТЭХ-ийн 31 дүгээр зүйлд “Татвар төлөгч татварын тайланг дараагийн татварын жилд багтаан залруулж болно” гэж заасны дагуу татвар төлөгчдөд тайлан ирүүлэх талаар мессеж, мэйл хүргүүлэн ажиллаж байгаа хэдий ч 2,758 иргэн буюу 27.4 хувь нь 2022 оны байдлаар орлогоо тайлагнаж, 2.2 тэрбум төгрөгийн татвар төлж, 8,390 иргэнээс татвар хураах боломжийг алдсан байна.

3.3.6 Худалдаа эрхлэгчид борлуулалтын 24 орчим хувьд цахим и-баримт олгосон байна.

3.3.7 Иргэн, аж ахуйн нэгжид 2019-2022 онд эдлүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн татварын шинэчлэл хийхээс өмнөх 2019 онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн байна. Үүнд татварын байгууллага 2,118.7 тэрбум, гаалийн байгууллага 884.9 тэрбум төгрөг, нийт 3,073.6 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна.

3.3.8 ААНОАТ-ын тухай хуулийн дагуу чөлөөлөлтийг 3,985 татвар төлөгч, 4,634 татвар төлөгч аж ахуйн нэгжид, ХХОАТ-ын тухай хуулиар 722 ажил олгогч, 1,279,495 иргэнд, НӨАТ-ын тухай хуулиар 19,881 иргэн, аж ахуйн нэгжид тус тус эдлүүлсэн байна.

Хүснэгт 11. Татварын зарлага, /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	Нийт дүн	2019 2022 зөрүү
Татварын орлого	9,813.1	8,511.6	11,299.9	15,459.0	45,083.6	1.6
Татварын нийт хөнгөлөлт, чөлөөлт	522.3	906.3	968.2	1199.1	3,073.6	2.3
Татварын орлогод татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эзлэх хувь	5.3	10.6	8.6	7.8	8.1	-
Үүнээс: Татварын байгууллага	307.5	703.8	642.0	842.9	2,188.7	2.7
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	53.8	201.5	287.8	443.3	932.6	8.2
Хувь хүний орлогын албан татвар	75.1	386.9	181.5	202.2	770.6	2.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар	178.6	115.4	172.7	197.4	485.5	1.1
Үүнээс: Гаалийн байгууллага	214.8	202.5	326.2	356.2	884.9	1.7
Гаалийн албан татвар	27.5	30.7	72.4	63.5	166.6	2.3
Онцгой албан татвар	125.1	104.0	129.6	185.2	418.8	1.5
Нэмэгдсэн өртгийн албан татвар	62.2	67.8	124.2	107.5	299.5	1.7

Эх сурвалж: Сангийн яам

3.3.9 Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос, үр тариа, тэжээл болон бусад барааны чөлөөлөлтийг 347 татвар төлөгч, гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар чөлөөлөлтийг 247 татвар төлөгч, онцгой албан татварын тухай хуулиар 3,889 татвар төлөгчийг татвараас хөнгөлж, импортын бараанд НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийг 392 татвар төлөгчид үзүүлсэн байна.

3.3.10 Шинээр мөрдөгдөж буй татварын ерөнхий хуулиар татвар төлөгчид ногдох хөнгөлөлтийн төрлийг нэмэгдүүлж, төлсөн татвараас буцаан авах боломжийг өргөжүүлснээр буцаан олголтын хэмжээ 2019 оноос 55.2 хувиар өсөж, 2022 онд 64.1 тэрбум төгрөгийг 4,133 татвар төлөгчид олгожээ.

3.3.11 Татварын шинэчлэл хэрэгжиж эхэлсэн 2020-2022 онд 7,730 татвар төлөгчид нийт 113.8 тэрбум төгрөгийн татварын буцаан олголт хийсэн байна.

Хүснэгт 12. Татварын буцаан олголт, /тэрбум төгрөгөөр/

№	Хуулийн заалт	Буцаан олголтын төрөл	2020 он		2021 он		2022 он	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	22.1	Татварын 90 хувийн хөнгөлөлт	297	2.0	2491	36.6	3933	59.2
2	28.4	Илүү төлөлтөө буцаан авах	484	2.2	178	1.1	106	2.5
3	22.5.1	Алслагдсан бүсийн хөнгөлөлт	49	2.3	57	3.3	85	2.1
4	22.5.10	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хөнгөлөлт	4	0.0	3	0.2	3	0.1
5	22.5.6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажил олгогчийн хөнгөлөлт	27	1.8	7	0.2	6	0.2
Нийт			861	8.4	2736	41.3	4133	64.1

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

3.3.12 Тухайлбал, ААНОАТ-ын 22 дугаар зүйлийн 22.1¹⁰-д заасны дагуу 3,933 аж ахуй нэгжид 59.2 тэрбум төгрөг, 22.5.1¹¹ дүгээр заалтыг үндэслэн 85 аж ахуйн нэгжид 2.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

3.3.13 Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 09, 2020 оны 12 дугаар сарын 25-нд “Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай хууль” 2 удаагийн хууль баталж, 2020 онд 145,199 татвар төлөгчийн 64.5 тэрбум төгрөг, 2021 онд 341,800 татвар төлөгчийн 47.7 тэрбум төгрөгийг торгууль, алдангиас тус тус чөлөөлсөн байна.

3.3.14 Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 7.2-т заасан хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины онцгой албан татварыг чөлөөлөх, 50 хүртэлх хувиар хөнгөлөх заалтыг 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон байна.

3.3.15 ГЕГ-аас уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалтыг үндэслэн эдгээр автомашинд ногдох орлогыг 2019-2022 он хүртэл бензин, дизель автомашины онцгой албан татварын 50 хувиар тооцож нийт 539.8 тэрбум төгрөгийн татвар ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлжээ. Сангийн яам уг орлогыг нь МУНТГТ-ын тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн хэдий ч татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр нөлөөг үнэлэх, статистик мэдээлэл бэлтгэж олон нийтэд мэдээлэх зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр тайлагнасан байна.

3.3.16 Засгийн газрын 2014-2020 оны хооронд ГТГТ-ын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь заалтыг үндэслэн нэр бүхий 4 ААН-д хамаарах 41.8 тэрбум төгрөгийн татварын төлөх хугацааг 2 жилийн хугацаагаар хойшлуулах шийдвэр гаргасан боловч тогтоосон хугацааны эцэст 2.0 тэрбум төгрөгийн төлөлт хийгдэж, нийт 39.8 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг төлөлгүй хойшлуулсаар ирсэн байна.

Хүснэгт 13. Төлөлт удааширсан гаалийн албан татвар, /тэрбум төгрөгөөр/

№	Засгийн газрын шийдвэр	Аж ахуйн нэгжийн нэр	Төлөх хугацааг хэтрүүлсэн татварын дүн	Барагдуулалт	Үлдэгдэл
1	Засгийн газрын 2014 оны 284 дүгээр тогтоол	Эрэл ХХК	5.0	-	5.0
2	Засгийн газрын 2014 оны 317, 2015 оны 191, 2017 оны 191 дүгээр тогтоол	Мон цемент билдинг материалс ХХК	22.9	2.0	20.9
3	Засгийн газрын 2020 оны 176 дугаар тогтоол	Вестернхолд ХХК	10.6	-	10.6
4	Засгийн газрын 2019 оны 139 дүгээр тогтоол	ТОСК	3.3	-	3.3
ДҮН			41.8	2.0	39.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

¹⁰ ..., энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө

¹¹ ..., энэ хуулийн 7.4.1-д заасан албан татвар ногдох орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар

БҮЛЭГ 4. ТАТВАРЫН ӨР 2022 ОНЫ БАЙДЛААР 3,276.6 ТЭРБУМ ТӨГРӨГ БОЛЖ ӨССӨН НЬ КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛААС ШАЛТГААЛСАН БАЙНА.

4.1.1 Хуулийн шинэчлэлийн хүрээнд татварын өр хураах үйл ажиллагаатай холбоотой татварын байгууллагын гүйцэтгэлийн бие даасан эрх мэдлийн зохицуулалтыг тусгаж хуульчилсан байна.

4.1.2 Татвар төлөгч иргэн, хуулийн этгээд хуулиар ногдуулсан татварыг хугацаандаа төлөөгүйгээс үүссэн өрийн хэмжээ 2019 онд 1,164.8 тэрбум төгрөг байснаас 2.8 дахин өсөж 3,276.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 14. Татварын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөгөөр/

Татварын алба /Албан татварын төрөл/	2019 он	2020 он	2021 он	2022 он	2019/2022 зөрүү	
					Дүн	Хувь
Дүүрэг, сумын төсөв	183.0	221.5	282.8	613.0	430.0	234.9
Нийслэл, аймгийн төсөв	121.5	170.5	248.3	115.7	-5.7	(4.7)
Улсын төсөв	860.2	1,167.5	1,762.6	2,547.9	1,687.6	196.2
Автын агаарын бохирдлын төлбөр	3.6	4.4	5.4	6.6	3.0	83.6
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	90.9	145.4	263.8	648.7	557.8	613.8
Алтны үнийн өсөлтийн албан татвар	18.7	18.7	18.7	0.1	-18.6	(99.7)
АМНАТ	88.8	138.5	247.5	556.8	468.0	527.2
Дотоодын архины ОАТ	3.4	3.4	3.5	3.5	0.1	4.3
Дотоодын бараа, үйлчилгээний суутгасан НӨАТ	650.8	852.6	1,218.7	1,326.9	676.0	103.9
Дотоодын спиртийн ОАТ	1.0	1.3	1.4	1.6	0.6	58.3
Нүүрсний агаарын бохирдлын төлбөр	3.1	3.1	3.5	3.4	0.3	10.5
Томоохон эх үүсвэрийн агаарын бохирдлын төлбөр	0.0	0.0	0.0	0.1	0.1	-
Ус бохирдуулсны төлбөр	0.0	0.0	0.1	0.2	0.2	-
НИЙТ	1,164.8	1,559.5	2,293.7	3,276.6	2,111.9	181.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газар, Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл

4.1.3 Нийт өрийн үлдэгдлийн 40.5 хувь дотоодын бараа үйлчилгээнд суутгасан НӨАТ, 19.2 хувь ААНОАТ, 17.0 хувь АМНАТ, 22.2 хувь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын, 1.0 хувь бусад татварын өр байна.

4.1.4 Татварын өрийн үлдэгдлийн судалгаагаар 41.7 хувь буюу 1,367.1 тэрбум төгрөг нь 2019 оноос өмнө, 58.3 хувь буюу 1,909.5 тэрбум төгрөг нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөлөөгөөр 2020-2022 оны хооронд үүссэн байна. Нийт өрийн 26.8 хувь буюу 877.8 тэрбум төгрөг нь эргэн төлөгдөхөд хүндрэлтэй, олон жилийн насжилттай өр байна.

4.1.5 Бүтээгдэхүүн хуваах гэрээний маргаантай 289.2 тэрбум, санхүүгийн тайлангаа удаан хугацаагаар гаргаагүй улсын бүртгэлээс хасахаар хүлээгдэж буй хуулийн этгээдийн 105.6 тэрбум, санхүүгийн хүндрэлд орсон ТӨХК-ийн 353.6 тэрбум, хариуцагчийг эрэн сурвалжилж буй 102.1 тэрбум, дампуурсан хуулийн этгээдийн 16.6 тэрбум, бусад 10.7 тэрбум, нийт 877.8 тэрбум төгрөгийн татварын өрийг барагдуулахад бодит хүндрэл үүссэн байна.

4.1.6 ТЕГ нь Сангийн Сайдын 2019 оны 307 дугаар тушаалаар баталсан “Өртэй татвар төлөгчийн хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журам”, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/263 тушаалаар “Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу татварын өрийг хураах албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

4.1.7 Татварын байгууллага нь 2020-2022 онд 70,251 татвар төлөгчийн 6,678.0 тэрбум төгрөгийн татварын өрөнд нэхэмжлэх илгээх, 5 татвар төлөгчийн 2.2 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлд авлага битүүмжлэх, 11,611 татвар төлөгчийн 1,892.7 тэрбум төгрөгийн өрөнд банкин дахь данс битүүмжлэх, 414 татвар төлөгчийн 29.5 тэрбум төгрөгийн өрөнд данс битүүмжлэх тухай мэдэгдэл хүргүүлэх, 67 татвар төлөгчийн 97.9 тэрбум төгрөгийн татварт эд хөрөнгө битүүмжлэх тухай мэдэгдэл хүргүүлэх, 27 татвар төлөгчийн 14.8 тэрбум төгрөгийн

өрөнд эд хөрөнгө битүүмжлэх, 2 татвар төлөгчийн өрийг барагдуулах дуудлага худалдааг зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээс нийт 8,715.1 тэрбум төгрөгийн өрийн 58.9 хувь буюу 5,137.1 тэрбум төгрөг нь барагдсан байна.

Хүснэгт 15. Хүндрэлтэй өрийн хэмжээг хассан татварын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөгөөр/

Татварын алба, төрөл	2021.12.31-с өмнөх	2022 он	Нийт дүн
НИЙТ	1,524.6	1,752.0	3,276.6
Аймгийн татварын хэлтэс	164.2	286.4	450.6
Дүүргийн татварын хэлтэс	749.0	644.3	1,393.4
Том татвар төлөгчийн газар	431.1	643.9	1,075.0
Нийслэлийн татварын газар	180.3	177.3	357.7

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

4.1.8 Татварын өрөнд 2020 онд 6.7 тэрбум төгрөг, 2021 онд 1.9 тэрбум төгрөгийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хурааж, битүүмжилсэн байна. Мөн 2022 онд 94.8 тэрбум төгрөгийн татварын өрөнд 5 үл хөдлөх хөрөнгө, 474.2 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал битүүмжилснээс 1.4 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан нь битүүмжилсэн хөрөнгийг, мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа удаашралтай, хангалттай үр дүнд хүрч чадахгүй байна.

Татварын өрийн үлдэгдэл өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- ❖ Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр татвар төлөгч бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа доголдож, санхүүгийн ашигт нь сөргөөр нөлөөлсөн нь хуулиар ногдуулсан татварыг хурааж төсөвт төвлөрүүлэхэд эрсдэл учирсан;
- ❖ 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлан мөрдөж эхэлсэн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ,
- ❖ Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахлын үед БНХАУ-ын хил хаагдсан, бараа, материал түүхий эдийн нийлүүлэлт буурсан, тээвэр логиستيкийн саатал, гадаад төлбөр тооцоо зэрэг шууд нөлөөлөл зах зээлд үүссэн;
- ❖ Засгийн газрын 2020 оны 161 дүгээр тогтоол, ТЕГ-ын Гамшгийн удирдлагын багийн хурлын шийдвэрээр 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс ТЕХ-ийн 12 дугаар бүлэг, 63 дугаар зүйлийн 63.1.1-63.1.4-д заасан “Татварын өрийг үйл маргах журмаар буюу татвар төлөгчийн банкин дахь дансыг битүүмжлэх” замаар татварын өр гаргуулах үйл ажиллагааг зогсоож, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанаас өмнө татварын өр хураах зорилгоор битүүмжилсэн татвар төлөгчийн арилжааны банкин дахь дансыг нээх мэдэгдлийг арилжааны 12 банканд хүргүүлэн 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 5,153 татвар төлөгчийн банканд байршсан 257.9 тэрбум төгрөгийн өртэй 31,630 дансны битүүмжлэлийг цуцлах ажиллагааг хийсэн;
- ❖ Мөн 2021 оны 5 дугаар сарын 19-ны өдөр 128.2 тэрбум төгрөгийн татварын өрд хамаарах 540 татвар төлөгчийн арилжааны 12 банкин дахь дансны битүүмжлэлийг цуцалсан;
- ❖ “Шинэ сэргэлтийн бодлого-Аялал жуулчлал”-ын салбарыг сэргээх тэргүүлэх бодлогын талаар санал солилцон уулзалтын хүрээнд Засгийн газраас аялал жуулчлал, зочид буудлын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1.5 тэрбум төгрөгийн татварын өртэй 39 татвар төлөгчийн арилжааны банкин дахь дансны битүүмжлэлийг цуцлах шийдвэрийг гаргасан;
- ❖ Татвараа хугацаандаа төлөөгүй үед татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай Засгийн газрын 2020 онд гаргасан шийдвэрийн дагуу 145,199 татвар төлөгчийн 64.5 тэрбум төгрөг, 2021 онд 341,800 татвар төлөгчийн 47.7 тэрбум төгрөгийг торгууль, алдангиас чөлөөлсөн;

4.1.9 Татварын орлогыг нягтлан бодох бүртгэлийн “мөнгөн суурь”-аар бүртгэснээс 3,276.6 тэрбум төгрөгийн татварын авлага санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.

4.1.10 Татварын өрийн үлдэгдлийг жилийн эцэст харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулдаг эсэх нь тодорхойгүй, зөвхөн татварын цахим системийн үлдэгдлээр тооцож байгаагаас гадна бусад эх үүсвэртэй тулган баталгаажуулахад хүндрэлтэй, түүнд тавих хяналт сул, зөрүү үүсэх эрсдэлтэй байна.

4.1.11 ТЕГ-аас аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатанд өгсөн судалгаагаар 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх татварын өрийн үлдэгдлийг 3,688.0 тэрбум төгрөгөөр мэдээлсэн боловч аудитын талбар, тайлагналын үе шатанд 411.4 тэрбум төгрөгөөр бууруулж дүнг 3,276.6 тэрбум төгрөг болгон өөрчилсөн.

4.1.12 Татварын удирдлага, мэдээллийн системийн аюулгүй ажиллагааны дүрэм журам, шаардлагаас үүдэж татварын өрийн үлдэгдлийг аудитаар тулган баталгаажуулах боломж бага, түүвэрчлэн шалгах нөхцөл хүндрэлтэй байсан.

4.1.13 Татварын өр нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн зохицуулалт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хуримтлагдахад хүрсэн боловч барагдуулах талаар дүн шинжилгээ хийж, эрчимжүүлэх шаардлагатай байна.

4.2 Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа нэг үе шаттай болж, татвар төлөгчдөд чирэгдэл багатай үйлчлэх нөхцөл бүрдсэн байна.

4.2.1 Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу ТЕГ болон аймаг, нийслэлийн татварын хэлтсийн дэргэд “Маргаан таслах зөвлөл”-ийг байгуулсан байна.

4.2.2 ТЕХ-ийн дагуу татварын акттай холбогдон гарсан маргааныг Татварын Маргаан таслах зөвлөлд хандаж шийдвэрлүүлэх, МТЗ-өөс гарсан шийдвэрийг гомдол гаргагч хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шүүхэд хандан гомдлоо хянуулах боломжтой юм.

4.2.3 МТЗ нь 2020 оныг хүртэл 2 үе шаттай байсныг Татварын хуулийн шинэчлэлээр хялбаршуулан, нэг үе шаттай байхаар зохицуулсан нь татварын асуудлаас үүдсэн гомдол, маргааны шийдвэрлэлтийн хугацааг багасгах, татвар төлөгчдөд цаг хугацаа, санхүү, хөрөнгийн чирэгдэл багатай үйлчлэх давуу талыг бий болгохоор зорьсон байна.

4.2.4 МТЗ-ийн бүрэлдэхүүнийг ТЕГ-т Сангийн сайдын, аймаг, нийслэлийн татварын хэлтэст ТЕГ-ын даргын тушаалаар СЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9-11 гишүүнтэйгээр томилж чөлөөлдөг байна.

4.2.5 Татварын маргаан таслах зөвлөлд 2019-2022 онд нийт 623 гомдол ирүүлснээс 416 гомдлыг хянаж, нийт 14,664.0 тэрбум төгрөгийн зөрчилд 1,332.0 тэрбум төгрөгийн татварын акт тогтоосноос 114.0 тэрбум төгрөгийн актыг татвар төлөгчийн талд, 1,218.0 тэрбум төгрөгийн актыг татварын албаны талд шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 16. Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт

Он	Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдлын тоо					Татварын улсын байцаагчийн актын мөнгөн дүн /тэрбум/		Шийдвэрлэлтийн мөнгөн дүн /тэрбум/			
	Эхний үлдэгдэл	Тухайн онд ирсэн	Шийдвэрлэсэн	Эцсийн үлдэгдэл	Шийдвэрлэлтийн хувь	Зөрчил	Төлбөр	Татвар төлөгчийн талд	Хувь	Татварын албаны талд	Хувь
2019	142	114	134	122	52	754.7	81.4	46.7	58	34.5	42
2020	122	33	116	32	75	450.0	27.1	4.9	18	22.3	82
2021	32	69	88	13	87	8,633.9	796.4	51.5	6	744.9	94
2022	13	98	78	33	70	4,825.9	426.7	10.4	4	416.3	96
НИЙТ	142	314	416	33	67	14,664.3	1,332.0	114.0	22	1,218.0	78

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

4.2.6 ТЕГ, НТГ дэргэдэх МТЗ-ийн улсын магадлагч нарын тоо хязгаарлагдмал, гомдол, саналын тоо олон, том татвар төлөгчдөөс гаргасан гомдлыг шийдвэрлэхэд цаг хугацаа шаарддаг зэрэг хүчин зүйлсээс хамаарч МТЗ-д ирүүлсэн нийт гомдлын шийдвэрлэлт 67 хувь, 2019 онд 74.5 тэрбум төгрөгийн 122, 2020 онд 385.0 тэрбум төгрөгийн 32, 2021 онд 353.9 тэрбум тэрбум төгрөгийн 13, 2022 онд 71.3 тэрбум төгрөгийн 33 гомдлыг шийдвэрлэж амжилгүй, он дамжуулан хянасан байна.

4.2.7 МТЗ-д ирүүлж буй гомдлын тоог татварын бодлогын шинэчлэл хийгдэхээс өмнөх онтой харьцуулахад 145-аар буурсан боловч мөнгөн дүн 345.3 тэрбум төгрөгөөр өссөн нь сүүлийн хоёр жилийн хугацаанд Оюутолгой ХХК, Петрожайна дачин тамсаг Монгол ХХК, Доншин корпорац зэрэг уул уурхайн том компаниудтай холбоотой гомдлыг шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

БҮЛЭГ 5. ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРГӨЖИЖ, ТАТВАРЫН ЗОРИЛГООР ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СТАНДАРТ, ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ISO/IEC 27001:2013 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛСЭН БАЙНА.

5.1.1 Татварын алба ТЗТБ, төрийн тусгай чиг үүргийн нийт 36 байгууллагаас 53 нэр төрлийн мэдээлэл гаргуулан авч, үйл ажиллагаандаа ашиглахаар мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах гэрээ байгуулснаас 18 байгууллагын 22 төрлийн мэдээллийг автомат мэдээллийн сангаас, 16 байгууллагын 29 нэр төрлийн мэдээллийг цахим шуудангаар, 2 байгууллагаас 2 нэр төрлийн мэдээллийг албан бичгээр хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 17. Хөндлөнгийн мэдээллийн сангийн бүрдэлтийн талаарх мэдээлэл

Д/д	Байгууллагын тоо	Мэдээллийн тоо	Мэдээлэл авах хэлбэр	Мэдээлэл авах хугацаа, давтамж	Зохицуулагдаж буй журам, гэрээ, бусад эрх зүйн баримт бичиг
1	18	22	Сервис /автомат/	тухай бүр, 7 хоног, сар	ТЕХ-ийн 34 дүгээр зүйл
2	16	29	Цахим шуудан	сар, улирал, хагас жил, жил	ТЕХ-ийн 34 дүгээр зүйл
3	2	2	Албан бичгээр	тухай бүр, сар	ТЕХ-ийн 34 дүгээр зүйл
Нийт	36	53			


Эх сурвалж: Татварын ерөнхий газар

5.1.2 Сангийн сайдын 2019 оны 69 дүгээр тушаалаар Татварын албаны нууцад хамаарах 14 төрлийн мэдээллийн жагсаалтыг баталсан байна.

5.1.3 Татварын алба нь татвар төлөгчийн талаарх мэдээлэл, хөндлөнгийн мэдээллийг татварын орлогыг нэмэгдүүлэхэд ашиглахдаа Монгол Улсын 4 хууль, Олон Улсын 1 конвенц, Засгийн газар, Сангийн сайд, ТЕГ-ын даргын баталсан 7 журмыг, татвар төлөгч иргэн ААН-ийн нууцыг хамгаалахтай холбоотой Сангийн сайдын баталсан 2, ТЕГ-ын даргын баталсан 2 журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

5.1.4 Татварын албаны мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг ТЕГ-ын даргын 2021 оны А/19 дугаар тушаалаар баталсан “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журам”-ын 9.1-д заасны дагуу ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа нэгж, албан хаагч хариуцаж, чиг үүргийн зохион байгуулалтад нэгжийн дарга хяналт тавьж ажиллаж байна.

Дүрслэл 8. Татварын удирдлагын нэгдсэн систем болон татварын процесс үйл ажиллагааны хоорондын уялдаа



Эх сурвалж: МТТ-ийн танилцуулга өмнө ба одоо

5.1.5 Хэдийгээр мэдээлэл солилцох гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, АМГТГ-аас авч буй мэдээллийн төрлийг нэмэгдүүлэх, Орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгалийн нөөц ашиглах тусгай зөвшөөрөл, Барилга хот байгуулалтын яамнаас газар өмчлөх болон эзэмших зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийг цаг тухай бүр цахимаар авдаг болох, мэдээллийн үнэн зөв байдлыг хангуулах нь татвар ногдуулалтын үйл ажиллагааг сайжруулж, ногдлыг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болохоор байна.

5.2 ТЕГ татвар төлөгч, татварын албаны мэдээллийн нууцлагдсан, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001:2013 стандарт, Татварын зорилгоор харилцан мэдээлэл солилцох стандарт, гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

5.2.1 Татварын шинэчлэлийн хүрээнд тодорхойлсон зорилт бүрийг мэдээллийн систем, программ хангамжид хөгжүүлэлт хийх замаар хэрэгжүүлж, татвар төлөгчийн мэдээллийн их өгөгдлийн санг бий болгон, “Machine learning” алгоритмыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр олон улсын түвшинд хүрсэн шинэчлэл болсон байна. Үүнд:

- ❖ 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон “TaxAct” программын 6 модулийг “Татварын удирдлагын нэгдсэн систем” /TAIS/-ийн 28 модульд шилжүүлж, 1 жилийн хугацаанд параллель байдлаар ашигласан байна. Мөн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Хүний хувийн мэдээллийг хамгаалах зорилгоор 2 factor authentication аюулгүй байдлын нэвтрэлтийг холбожээ.
- ❖ Удирдлагын нэгдсэн дашбоардыг хөгжүүлж, татвар төлөгчийн бүртгэл, тайлан, төлөлт, тооцоолол, татварын өр, маргаан таслах зэрэг нийт 6 бүлэг, 5 сегмент, 50 гаруй төрлийн өгөгдлийг өдөр, сар, улирал, хагас жилээр шинэчлэх тохиргоог хийж удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангах тогтолцоог бүрдүүлсэн байна.
- ❖ Монгол банкнаас харилцагчийн дансны мэдээллийг цахим хэлбэрээр мэдээлэл солилцдог болсноор татвар төлөгчийн бүртгэлд дансны мэдээлэл тухай бүр шинэчлэгдэн, цахим төлбөрийн баримтын системд татвар төлөгчийн дансны мэдээллийг холбосноор татвар ногдуулах орлого нэмэгдэх боломжтой болсон байна.

5.2.2 Татварын алба нийт 2,086,479 татвар төлөгч иргэн, 244,346 татвар төлөгч хуулийн этгээд, 40 татварын төрлөөр бүртгэлтэй 7,268,410 (эх сурвалж: Татвар төлөгчийн бүртгэлийн тоо файл, 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар) татвар төлөгчийн татварын төрлийн болон татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлан хүлээн авах, татвар төлөлт, татварын өр барагдуулах зэрэг үндсэн үйл ажиллагааны хүрээнд Татварын удирдлагын нэгдсэн системийн тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

5.2.3 Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах олон улсын ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын хамрах хүрээ, хүний нөөцийн аюулгүй байдал, биет аюулгүй байдал, мэдээлэл харилцан солилцох урсгал, хугацааны туршид мэдээллийг хамгаалах, хадгалах, дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулсан дагаж мөрдөх 33 баримт бичиг, журмыг шинээр боловсруулан батлуулж, 2 журамд нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлж байна.

5.2.4 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO27001 олон улсын стандартыг нэвтрүүлэн ажиллаж байгаа боловч мэдээллийн аюулгүй байдлын тасралтгүй үйл ажиллагааг хангах, түүнийг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий мэргэжилтэн, МАБ-ын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий МАБ-ын аудитор буюу хариуцан ажиллах нэгж, албан хаагч, албан тушаалын тодорхойлолтыг бий болгож батлаагүй байна.

Энэ нь “Кибер аюулгүй байдлын тухай”, “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулиуд болон “Алсын хараа 2050” үзэл баримтлалын 8 дугаар бүлэгт заасан мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагааг хэрэгжүүлэх заалттай нийцэхгүй байна.

ТаЕГ-ын Мэдээллийн аюулгүй байдлын газраас эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын өнөөгийн байдалд шинжилгээ хийж зөвлөмж өгсөн байна.

5.2.5 Тагнуулын ерөнхий газраас ТУНС, Цахим татварын систем (etax.mta.mn), Цахим төлбөрийн баримтын систем /ЦТБС/ (ebarimt.mn) зэрэг 3 системд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.


Хүснэгт 18. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний дүн

№	Системийн нэр	Эрсдэлийн түвшин		Илрүүлсэн эмзэг байдлын тоо	Өгсөн зөвлөмжийн тоо
		Дундаж	Бага		
1	Татварын удирдлагын нэгдсэн систем	2	2	4	4
2	Цахим татварын систем	2	5	7	7
3	Цахим төлбөрийн баримтын систем	1	4	5	5
	Нийт дүн	5	11	16	16

Эх сурвалж: Тагнуулын ерөнхий газрын 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 795 тоот албан бичиг

5.2.6 ЦТБС, ЦТС, ТУНС-ийн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний эмзэг байдлын шинжилгээгээр ТЕГ-ын Мэдээлэл технологийн төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төв УҮГ-т авч хэрэгжүүлэх 17 арга хэмжээг зөвлөсөн байна

Дүрслэл 9. Эрсдэлийн түвшин болон зөвлөмжийн тоо



5.2.7 Зөвлөмжид тусгасан 16 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч “нэгдсэн нэвтрэлтийн системд тоон гарын үсэг ашиглан нэвтрэх боломжийг бүрдүүлэх” талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эх сурвалж: Тагнуулын ерөнхий газрын 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 795 тоот албан бичиг

5.2.8 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийн эзний зөвшөөрлийг авах, цахим хэлбэрээр мэдэгдэл хүргэх үйл ажиллагааны программын хөгжүүлэлтийг ТУНС-ийн процесс бүрд тусган, нэмэлт өөрчлөлтийг оруулжээ.

5.3 Төрийн болон албаны нууц мэдээлэлд нэвтрэх албан тушаалтанд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр эрх олгосон байна.

5.3.1 “Төрийн болон албаны нууцын тухай хууль /ТБАНТХ/-ийн 5.1.1-д “төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг” хэмээн тодорхойлсон байна.

5.3.2 ТЕГ-ын даргын 2019 оны 5 дугаар сарын 21-ний А/85 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар 1 дүгээр түвшний төрийн нууцтай танилцах эрх бүхий 4, 2 дугаар түвшний төрийн нууцтай танилцах эрх бүхий 12, нийт 16 албан тушаалтны жагсаалтыг баталж, аюулгүй байдлын шалгалтад хамруулах хүсэлтийг Тагнуулын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлсэн боловч, эрх олгоогүй байна.

5.3.3 Энэ нь ТБАНТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Энэ хуулийн 21 дүгээр зүйлд зааснаас бусад төрийн нууцтай танилцах ажил, албан тушаалд аюулгүй байдлын шалгалтын дүнг үндэслэн тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгосон иргэнийг ажиллуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

5.3.4 ТЕХ-ийн 34 дүгээр зүйлд төрийн захиргааны төв болон хууль хяналтын байгууллагаас мэдээлэл авах зохицуулалтыг тусгасан бөгөөд, нийт 11 байгууллага татварын байгууллагад хувийн мэдээлэл, хөрөнгө орлогын болон хөрөнгийн өөрчлөлтийн, хуулийн этгээдийн бүртгэл, өөрчлөлт, санхүүгийн бүх мэдээллийг 5 минут тутамд, шаардлага үүссэн тухай бүрд авах эрхтэй байхаар зохицуулсан байна.

5.3.5 Тухайлбал, ТЭХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.8.1 , 34.13.1 , 34.14.1 , 34.14.2 , 34.15.2 , 34.19.2 , 34.23 , 34.24 , 34.25.1 , 34.25.2 -т заасны дагуу ТЭГ мэдээллийг гаргуулан авах эрхтэй ч дээрх заалтуудад хамаарах мэдээлэл нь “Хувь хүний нууцыг хамгаалах тухай”, “Төрийн болон албаны нууцын тухай”, “Нийтийн мэдээллийг ил тод болгох тухай хууль”-д заасны дагуу тусгай эрх бүхий байгууллагын аюулгүйн шалгалтад орж, шаардлага хангасан тохиолдолд мэдээлэл авах эрх үүсэхээр зохицуулалттай мэдээллүүд хамаарч байна.

5.3.6 Үүнд, ТЭХ-ийн 34.8.1-д “Монгол Улсын иргэний улсын бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл”-ийг, 34.23, 34.24 дүгээрт заасан хэсэгт “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн иргэдийн хувийн болон эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл байх бөгөөд УБЕГ, ЭМДС, НДС-аас шууд авахаар баталжээ.

5.3.7 Эдгээрээс УБЕГ, НДЕГ-тай харилцан мэдээлэл солилцохдоо татварын зорилгоор зөвхөн гэрээнд заасан тодорхой хүрээний мэдээлэл авч татварын үйл ажиллагаанд ашиглаж байна.

5.4 Олон улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, Дэлхийн 26 улстай байгуулсан давхар татварын гэрээг мөрдөж байна.

5.4.1 Монгол Улс нь 1991-2007 оны хооронд нийт 35 улстай Давхар татварын гэрээ (ДТГ) байгуулсан бөгөөд үүнээс 4 гэрээг цуцалж, одоогоор 26 улстай байгуулсан гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

5.4.2 Гадаадын улс орнуудтай мэдээлэл солилцох санамж бичгийн хүрээнд дараах 7 төрлийн мэдээллийг хүсэлтээр болон сайн дураар солилцон ажиллаж байна. Үүнд:

- Оршин суугч эсэхийн тодруулга;
- Компанийн бүртгэл;
- Татварын болон санхүүгийн тайлан;
- Банкны дансны үлдэгдэл болон гүйлгээнүүд;
- Эцсийн эзэмшигчийн мэдээлэл;
- Ажил гүйлгээ ба нэхэмжлэлүүдийг агуулсан дансны бүртгэлийн мэдээлэл;
- Татвар ногдуулахад шаардлагатай бусад мэдээллүүд байна.

Дүрслэл 10. Мэдээлэл авах хүсэлтийн тоо, улсын тоо



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

5.4.3 ТЭГ нь 2018-2022 оны хооронд гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох ажлын хүрээнд 27 татвар төлөгчтэй холбоотой 50 төрлийн мэдээлэл авах хүсэлтийг дэлхийн 12 улс руу явуулж мэдээлэл авсан байна.

5.4.4 Харин манай улсад 2020 онд Франц улсаас 4 төрлийн мэдээлэл авах 1 хүсэлт, 2022 онд БНЭУ-аас 6 төрлийн мэдээлэл авах 1 хүсэлт, Киргизстан улсаас 7 төрлийн мэдээлэл авах 1 хүсэлт, БНХАУ-аас 2 төрлийн мэдээлэл авахаар 1 хүсэлтийг хүлээн авсны дагуу хариуг хүргүүлжээ.

5.4.5 Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын “Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцох глобал форум”-д Монгол Улс 2026 он гэхэд татварын асуудалд санхүүгийн дансны мэдээллийг автоматаар солилцох олон улсын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсний дагуу дотоодын санхүүгийн байгууллагууд тайлагналын шаардлагыг хэрэгжүүлэх, дотоодын хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах, солилцсон мэдээллийн ашиглалтын журам зэрэг удирдлагын тогтолцоог бүрдүүлэх бэлтгэл ажлуудыг хийж байна.

5.4.6 Монгол Улсад байрладаг татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварыг тухайн жилийн төлбөл зохих татвараас хасаж тооцсон мэдээлэл дараах байдалтай байна.

Хүснэгт 19. ААНОАТ-ын тайлангаар гадаад улсад ногдуулан төлсөн албан татвараа хасаж тооцсон мэдээлэл, дүн, /тэрбум төгрөгөөр/

Гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар		2021 он		2022 он	
		ТТ-ийн тоо	Хасаж тооцсон дүн	ТТ-ийн тоо	Хасаж тооцсон дүн
МУ-д байрладаг татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварыг татвар төлөгчийн тухайн жилийн төлбөл зохих татвараас хасаж тооцох	Татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих татварын дүн	10	2.6	7	7.8
	Гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар ногдох орлогод МУ-ын татварын хуулийн дагуу ногдуулсан тохиолдолд төлбөл зохих албан татварын дүн	9	0.1	7	0.7
Нийт дүн		19	2.7	14	8.5

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

5.4.7 Монголын татварын алба анхны үнэ шилжилтийн хяналт шалгалтыг хийж, ирээдүйд шилжүүлэх 1.5 тэрбум ам.долларын алдагдлыг бууруулан тооцож, 649.0 тэрбум төгрөгийн татварыг үндэстэн дамнасан компанид ногдуулсан байна.

5.5 ТЕХ-ийн шинэчилсэн зохицуулалтын дагуу харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн бараа, ажил үйлчилгээний нөхцөл, үнийг тодорхойлсон “үнэ шилжилтийн 3 төрлийн тайлан”-г хянаж, хүлээн авч байна.

5.5.1 Татварын байгууллага нь ТЕХ-ийн 27 дугаар зүйлд заасан харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн бараа, ажил үйлчилгээний нөхцөл, үнийг тодорхойлсон “үнэ шилжилтийн 3 төрлийн тайлан”-г ТЕГ-ын даргын 2020 оны А/133 дугаар “Тайлангийн маягт, хавсралт мэдээ, нөхөх заавар батлах тухай” тушаалаар баталсан аргачлалын дагуу хянаж, хүлээн авч байна.

5.5.2 Үндэстэн дамнасан группийн орлого, татварын хуваарилалттай холбоотой улс бүрээр тайлагнах үнэ шилжилтийн тайлангийн ирц 91.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа хэдий ч групп компанид хамаарах ерөнхий үнэ шилжилтийн тайлангийн ирц 62.4 хувь, дотоод татвар төлөгчийн ажил гүйлгээг тусгасан дотоод үнэ шилжилтийн тайлангийн ирц 63 хувьтай байна.

5.5.3 ҮШТ нь татварын албанд үнэ шилжилтийн эрсдэлийн үнэлгээний шинжилгээг хийхэд гол мэдээллээр хангах, хяналт шалгалтад шаардлагатай мэдээллийг боловсруулах, татвар төлөгчдийг ач холбогдол бүхий ажил гүйлгээндээ үнэ шилжилтийн зарчмыг мөрдөж буйг харуулах арга хэрэгсэл болж байна.

5.5.4 Шинэчлэгдсэн хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд тайланг бүртгэж, хүлээн авах үйл ажиллагаа хийгдэж байгаа боловч үнэ шилжилтийн үндсэн тохируулга хийж, татварыг нөхөн ногдуулж татварын орлогыг нэмэгдүүлсэн, хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

БҮЛЭГ 6 ТАТВАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛЖ ХҮНИЙ ОРОЛЦООГҮЙГЭЭР, БОГИНО ХУГАЦААНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.

6.1.1 ТЕГ-ын Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний газраас 2019-2022 оны хооронд дүүрэг, орон нутаг дахь салбар нэгжүүдийн татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд нийт 20 удаагийн хяналт, шалгалт хэрэгжүүлж, 185.4 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, түүнийг арилгуулах 548 зөвлөмж өгсөн байна.

6.1.2 Байгууллагын стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлд 22 удаа хяналт тавьж, 1,713 зөвлөмж, Сангийн сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээ, байгууллагын болон харьяа нэгжүүдийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, сегментийн стратеги төлөвлөгөө зэрэгт нийт 65 хяналтын арга хэмжээ хэрэгжүүлж, 438 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

6.1.3 Татварын алба эрсдэлийн удирдлагын чиглэлээр татварын харилцаанд оролцогчдын эрсдэлийг оновчтой арга замаар тодорхойлох, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг хийж байна.

6.1.4 Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн мэдээлэл болон бусад этгээдээс хуулийн дагуу цуглуулсан мэдээллийг их өгөгдлийн сан болгон үүсгэж, үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

6.1.5 Ингэснээр эрсдэлийн удирдлага болон судалгаа, шинжилгээний ажлыг бодит цагийн горимоор түргэн шуурхай гүйцэтгэж байна. Их өгөгдлийг боловсруулах “Machine learning”-д суурилсан платформиос дараах загваруудыг боловсруулан гаргаж байна. Үүнд:

- ❖ Татвар төлөгчийн хууль тогтоомж мөрдөлтийн түвшнийг татвар төлөгчийн бүртгэл, тайлангийн ирц, татвар төлөлт, хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн татвар төлөгчийн зан хандлагыг 1-4 түвшнээр тодорхойлох;
- ❖ ААНОАТ-ын 4 жилийн тайлагналын байдалд үндэслэн дараа жилийн тайлангийн татвар ногдох орлого, хасагдах зардлын хэмжээг таамаглах, зөрүүг урьдчилан тогтоох;
- ❖ Татварын тайлагналын үзүүлэлт хоорондын уялдаатай байдалд шинжилгээ хийж, эрсдэлийн түвшнийг тодорхойлох;
- ❖ Татварын хяналт шалгалтын түүхэн мэдээлэлд үндэслэн татварын хяналт шалгалтад хамрагдаж буй татвар төлөгчийн зөрчлийн дүнг урьдчилан таамаглах;
- ❖ Татвар төлөгчийн харилцан хамаарлыг тогтоох, зөрүүтэй тайланг илрүүлэх.
- ❖ Татвар албаны их өгөгдлийн мэдээллийг боловсруулах, анализ хийх албан ёсны лиценз бүхий программ хангамжийг ашиглан боловсруулалт хийснээр өмнө нь дор хаяж 72 цаг боловсруулдаг байсан бол одоо их өгөгдлийн санд “Machine learning” алгоритмыг ашигласнаар 1-3 цагт их хэмжээний өгөгдөлд үндэслэн хийсэн судалгаа, шинжилгээний ажил бэлэн болдог болсон байна.

6.1.6 Эрсдэлийн удирдлага болон судалгаа, шинжилгээний ажлыг бодит цагийн горимоор түргэн шуурхай гүйцэтгэснээр татварын хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчийн тоо 4.3 дахин буурч, 1 татвар төлөгчид ногдох зөрчлийн дүн 12.1 дахин нэмэгдсэн байна.

АУДИТЫН ҮР ДҮН

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой Гаалийн ерөнхий газарт 13.9 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 25.9 тэрбум төгрөгийн албан шаардлага, Татварын ерөнхий газарт 5 зөвлөмж, Сангийн яаманд 3 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

ДҮГНЭЛТ:

Татварын шинэчлэлийн бодлого, түүний үр нөлөө сэдэвт аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Татварын багц хуулиудыг шинэчлэн баталж, холбогдох 28 хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, хэрэгжүүлж байгаа боловч холбогдох зарим татварын хуулиудыг уялдуулж өөрчлөх шаардлагатай байна.
- Татварын хуулийн шинэчлэлээр татварын хувь хэмжээг шатлан бууруулах, жижиг болон бичил бизнесийг дэмжих, хүн амын төвлөрлийг сааруулах, эдийн засгийн хямрал, Ковид-19 цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, татварыг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилт тавьж хэрэгжүүлснээр татварын бааз өргөжиж, улсын төсвийн нийт орлогын 70 гаруй хувийг татварын орлогоос бүрдүүлж байна.
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засаг болон татвар төлөгчдийн үйл ажиллагаанд үзүүлсэн сөрөг нөлөөллөөс үүдэж, татварын бодлого, хуулийн шинэчлэлийн хэрэгжилт, үр нөлөөг бодитоор хянаж, үнэлэх боломжийг хязгаарлаж байна.
- Нийгэм, эдийн засаг, иргэд аж, ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлж буй татварын нөлөөлөлд үнэлгээ хийх, татварын ачааллыг салбар, сегментийн хэмжээнд тооцон, дүн шинжилгээ хийх замаар төсвийн бодлогыг татварын бодлоготой уялдуулж эдийн засгийн жигд өсөлтөд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон жижиг бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, татвар ногдуулалт, хураалт, цахим и-баримт олголт хангалтгүй байгаа нь бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгчдийн хэмжээнд далд эдийн засгийг бууруулах зорилтод сөргөөр нөлөөлж байна.
- Татварын өрийн үлдэгдэл 2019 оноос 2.8 дахин өсөж 3,276.6 тэрбум төгрөгт хүрсэн нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, /Ковид-19/-ын цар тахлын үед хууль эрх зүйн хүрээнд татвар төлөлт, ногдуулалтыг хойшлуулсан зохицуулалтыг хэрэгжүүлснээс шалтгаалжээ.
- Татварын албадан гүйцэтгэх үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд бусад салбарын хуультай уялдаа сул байгаагаас үр дүнд хүрч чадахгүй байна.
- Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд мэдээлэл технологийн системийн хөгжүүлэлтийг хийж, татварын эрсдэлийн удирдлага болон судалгаа, шинжилгээний ажлыг бодит цагийн горимоор хэрэгжүүлснээр хяналтыг үр дүнтэй зохион байгуулах боломж бүрдсэн байна.
- Татварын хуулийн шинэчлэлтэй уялдуулж мэдээлэл авах эрх зүйн орчин сайжирсан ч эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгууллагынхаа албан тушаалтанд төрийн болон албаны нууцтай танилцах эрх олгож, зөрчил гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ:

Дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сангийн яаманд:

- Татварын ерөнхий хуульд заасан татварын хуулиудыг (Гаалийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль) татварын шинэчлэлийн шаардлагад нийцүүлж уялдуулах талаар шат, дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Татварын ачааллыг салбар, сегментийн хэмжээнд тооцож, иргэд аж, ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг бодитоор үнэлж, дүн шинжилгээ хийх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалыг баталж, хэрэгжүүлэх, татварын “эдийн засгийн жигд өсөлтөд дэмжлэг үзүүлж, тогтворжуулах” чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;
- Төсвийн бодлогыг татварын бодлоготой уялдуулан төлөвлөж, татварын орлогыг улс болон орон нутгийн төсөвт хуваарилах талаар холбогдох хуульд нийцүүлэн журамд өөрчлөлт оруулж, мөрдөж ажиллах.

Татварын ерөнхий газарт:

- Хувиараа болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, ногдуулалт, хураалтыг хүртээмжтэй зохион байгуулах, и-баримтын олголтоор дамжуулан тавих хяналтыг сайжруулах;
- Хуримтлагдсан болон эргэн төлөгдөхөд хүндрэл учирсан татварын өрийг барагдуулах талаар бодит арга хэмжээ авах;
- Татварын албадан гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг сайжруулах, салбар хоорондын уялдааг хангах замаар үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Татварын үйл ажиллагааг мэдээлэл технологийн дэвшилтэй уялдуулан бодит цагийн горимоор, оновчтой зохион байгуулж буй дэвшилтэт технологийг төрийн бусад байгууллагуудад таниулж, мэдээлэл солилцож байх;
- Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалахад анхаарч, холбогдох хуулиудыг мөрдөж ажиллах.

Хавсралтууд

Хавсралт 1. Татвар, төлбөр хураамжийн төрөл

№	Татвар, төлбөр, хураамжийн төрөл	Албан татварын				№	Татвар, төлбөр, хураамжийн төрөл	Албан татварын			
		Хувь хэмжээг тогтоож буй хууль, эрх бүхий этгээд	Хувь хэмжээг баталсан он	Ногдуулагч байгууллага	Төсвийн хуваарь			Хувь хэмжээг тогтоож буй хууль, эрх бүхий этгээд	Хувь хэмжээг баталсан он	Татвар ногдуулагч байгууллага	Төсвийн хуваарь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Хуулиар	2019.03.22	ТЕГ	УТ 60 хувь, ОНТ 40 хувь	16	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Аймаг, нийслэлийн ИТХ	2021.07.07	ТЕГ	ОНТ
2	Гаалийн албан татвар	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	2008 / нийт 16 удаа өөрчлөлт орсон	ГЕГ	Улсын төсөв	17	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	Ашигт малтмалын тухай хууль	2006	УУХҮЯ	ОНТ
3	Нэмэгдсэн өртгийн албан татвар	НӨАТ-ын тухай хууль	2015.07.09 2015	ТЕГ ГЕГ	Улсын төсөв Улсын төсөв	18	Газрын төлбөр	Газрын төлбөрийн тухай хууль, ЗГ	1997/ нийт 11 удаа өөрчлөлт орсон	БХБЯ-Газрын алба	ОНТ
4	Онцгой албан татвар	Хуулиар Засгийн газар	2022.07.06 2017.06.09	ТЕГ ГЕГ	Улсын төсөв Улсын төсөв	19	Галт зэвсгийн албан татвар	Галт зэвсгийн албан татварын тухай хууль	2015.08.07	ТЕГ	ОНТ
5	Автобензин, дизелийн түлшний албан татвар	Автобензин, дизелийн түлшний албан татвар	1995	ГЕГ	Улсын төсөв	20	Нийслэл хотын албан татвар	Нийслэлийн ИТХ	2021.07.07	ТЕГ	ОНТ
6	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	хуулиар	2019.11.22	ГЕГ	Улсын төсөв	21	Нохойны албан татвар	Хууль гараагүй	Хэрэгжээгүй		
7	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Гаалийн тарифын зөвлөл	2023.01.06	ГЕГ	Улсын төсөв	22	Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар	Хууль гараагүй	Хэрэгжээгүй		
8	Агаарын бохирдлын төлбөр	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	2010.06.24	ТЕГ	Улсын төсөв	23	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	Сум, дүүргийн ИТХ	2017	Сум дүүргийн засаг дарга	ОНТ
9	Улсын тэмдэгтийн хураамж	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль	2010.11.25/ нийт 50 удаа өөрчлөлт орсон	ТЕГ	ОНТ /11.2-т заасан хураамжийг Улсын төсөвт/	24	Байгалийн ургамал ашигласны төлбөр	Аймаг, нийслэлийн ИТХ	2012 / нийт 7 удаа өөрчлөн найруулсан	Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан	ОНТ
10	Ус бохирдуулсны төлбөр	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2019.05.12 БОАЖЯС, СС 2021 А/406/226	ТЕГ	Улсын төсөв	25	Усны нөөц ашигласны төлбөр	Засгийн газар	2012 / нийт 7 удаа өөрчлөн найруулсан	Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан	ОНТ
11	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	Газрын тосны тухай хууль	2014.07.01	УУХҮЯ-ГТГ	УТ 100 хувь, /ОХНС 30 хувь/	26	Рашаан ашигласны төлбөр	Аймаг, нийслэлийн ИТХ	2012 / нийт 7 удаа өөрчлөн найруулсан	БОАЖЯ, Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан	ОНТ
12	Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Газрын тосны тухай хууль	2014 /нийт 8 удаа өөрчлөлт орсон	УУХҮЯ-ГТГ	ОНТ 30 хувь, УТ 70 хувь	27	Ойн нөөц ашигласны төлбөр	Засгийн газар, БОАЖЯ	2012 / нийт 7 удаа өөрчлөн найруулсан	БОАЖЯ, Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан	ОНТ
13	Хувь хүний орлогын албан татвар	ХХОАТ-ын тухай хууль Аймаг, нийслэлийн ИТХ	2019.03.22	ТЕГ	Сум, дүүргийн төсөв	28	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2012 / нийт 7 удаа өөрчлөн найруулсан	БОАЖЯ, Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан	ОНТ
14	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	Аймаг, нийслэлийн ИТХ	2021.07.07			29	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2014.01.09	Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан	ОНТ
15	Малын тоо толгойн албан татвар	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2020.11.13	ТЕГ	Сум, дүүргийн төсөв	30	Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр	Хууль батлагдаагүй	Хэрэгжээгүй		

Хавсралт 2. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-1

Өмгөөлөгч нотариат, Тээврийн хэрэгсэл импортлогч иргэдийн ХХОАТ-аа 2022 онд тайлагнасан байдал

/2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар/

/төгрөг/

Д/Д	Татварын алба	Өмгөөлөгч, нотариатын үйл ажиллагаа эрхлэгч иргэн				Тээврийн хэрэгсэл импортлогч иргэн			
		Эрсдэлтэй татвар төлөгчийн тоо	Тайлагнасан	Борлуулалтын орлого	Ногдол	Эрсдэлтэй татвар төлөгчийн тоо	Тайлагнасан	Борлуулалтын орлого	Ногдол
1	Архангай	24	9	154,093,359.65	2,217,797.69	36	7	229,247,379.85	293,523.85
2	Багануур	19	6	287,566,276.60	3,420,716.06	35	7	1,245,251,919.71	1,992,899.14
3	Багахангай	2	2	49,559,906.48	-	7	1	5,763,940.90	576,394.09
4	Баянгол	520	171	8,832,146,672.56	274,235,003.21	1249	265	341,872,232,500.85	164,815,015.58
5	Баянзүрх	696	243	10,867,459,881.92	122,357,403.95	1720	301	98,379,637,747.79	174,725,575.91
6	Баян-Өлгий	33	18	426,351,800.32	3,351,595.94	20	6	430,220,999.43	309,400.02
7	Баянхонгор	22	10	93,633,125.30	853,651.00	32	10	692,890,087.23	7,601,131.87
8	Булган	15	5	69,652,676.17	139,275.00	26	14	544,483,475.55	5,550,250.00
9	Говь-Алтай	17	11	215,199,323.78	1,999,561.17	24	5	209,402,572.24	737,937.00
10	Говьсүмбэр	14	8	222,755,559.60	780,688.69	11	1	22,785,112.76	-
11	Дархан-Уул	54	21	464,726,698.19	1,857,282.68	94	8	95,410,274.08	836,100.00
12	Дорноговь	32	19	422,865,057.83	2,832,054.08	635	75	1,956,888,019.21	33,594,820.93
13	Дорнод	30	11	264,061,992.50	2,225,826.31	31	9	2,973,099,344.98	10,584,111.02
14	Дундговь	16	10	225,197,754.10	1,134,226.52	12	1	71,972,393.66	495,591.57
15	Завхан	24	12	157,275,545.83	2,355,446.62	41	5	597,883,225.97	444,647.00
16	Налайх	26	6	164,957,562.62	1,188,836.51	59	5	171,670,240.03	50,000.00
17	Орхон	59	30	1,159,515,938.97	20,642,275.57	99	17	1,104,820,935.80	2,371,939.57
18	Өвөрхангай	33	16	458,993,325.00	9,425,429.53	41	11	3,019,353,455.91	1,588,540.01
19	Өмнөговь	33	13	406,993,246.17	5,832,952.08	27	6	1,067,065,460.05	22,653,447.87
20	Сонгинохайрхан	159	52	1,490,977,258.22	21,032,957.30	736	97	31,058,975,935.56	97,444,456.48
21	Сүхбаатар	17	9	205,451,997.93	803,491.06	21	3	129,905,873.03	-
22	Сүхбаатар дүүрэг	363	126	6,614,608,579.34	228,810,165.04	553	98	39,167,034,939.57	117,510,994.10
23	Сэлэнгэ	41	14	375,182,788.50	2,029,693.95	110	17	279,437,884.24	750,747.14
24	Төв	40	8	519,062,554.76	876,680.60	81	12	1,425,722,782.69	983,240.82
25	Увс	24	10	283,917,169.41	830,309.74	51	17	14,112,784,609.85	2,256,469.00
26	Хан-Уул	550	196	10,840,878,935.25	122,749,756.16	1092	202	124,326,159,016.65	202,891,546.62
27	Ховд	32	20	561,274,445.90	11,031,168.60	53	24	2,546,899,027.35	16,525,285.08
28	Хөвсгөл	40	19	329,341,087.33	1,053,306.85	68	23	6,338,688,686.54	85,822,859.29
29	Хэнтий	31	17	418,844,770.40	585,141.13	41	8	683,445,897.33	10,516,364.75
30	Чингэлтэй	250	80	2,571,396,805.20	81,594,670.96	417	64	40,559,078,506.19	39,685,030.60
Дүн		3216	1172	49,153,942,095.83	928,247,364.00	7422	1319	715,318,212,245.00	1,003,608,319.31

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР - ТАТВАР ТӨЛӨГЧИД ҮЙЛЧЛЭХ ГАЗАР

Хавсралт 3. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-2

Алт тушаасан иргэд, ТЭДИ төвд үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн ХХОАТ-аа 2022 онд тайлагнасан байдал

/2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар/

/төгрөг/

Д/Д	Татварын алба	Алт тушаасан иргэн				ТЭДИ төвд үйл ажилгаа эрхлэгч иргэн			
		Эрсдэлтэй	Тайлагнасан	Борлуулалтын орлого	Ногдол	Эрсдэлтэй	Тайлагнасан	Борлуулалтын орлого	Ногдол
		татвар төлөгчийн тоо				татвар төлөгчийн тоо			
1	Архангай								
2	Багануур					1	1	37,715,200.00	377,152.00
3	Багахангай								
4	Баянгол	2	2	3,107,807,449.00	1,152,685.00	125	60	3,068,494,904.72	26,719,197.05
5	Баянзүрх	8	4	43,120,975,996.00	4,969,903.79	84	51	2,313,336,547.37	26,298,897.82
6	Баян-Өлгий								
7	Баянхонгор	8	8	8,196,399,726.22	2,756,800.00				
8	Булган								
9	Говь-Алтай								
10	Говьсүмбэр					1	0		
11	Дархан-Уул	6	5	112,801,294,813.92	25,567,020.43	31	17	757,440,621.61	12,956,955.92
12	Дорноговь					2	0		
13	Дорнод								
14	Дундговь								
15	Завхан								
16	Налайх								
17	Орхон					2	0		
18	Өвөрхангай								
19	Өмнөговь	1	1	273,849,035.90	523,975.50				
20	Сонгинохайрхан	1	1	8,167,361,749.00	13,545,851.32	43	13	388,628,320.33	4,613,425.47
21	Сүхбаатар								
22	Сүхбаатар дүүрэг	4	4	389,902,015,737.00	23,421,581.52	35	19	974,518,715.26	7,735,913.85
23	Сэлэнгэ	4	3	5,543,676,611.64	440,766.66	2	1	7,003,325.20	98,800.00
24	Төв					6	1	4,790,000.00	47,900.00
25	Увс								
26	Хан-Уул	11	7	316,050,486,788.10	44,279,768.15	63	31	2,820,606,702.24	14,446,437.99
27	Ховд	1	1						
28	Хөвсгөл					1	1	35,685,800.00	356,858.00
29	Хэнтий								
30	Чингэлтэй	10	6	202,360,228,557.12	12,968,980.21	58	30	1,089,794,155.99	11,766,072.43
Дүн		56	42	1,089,524,096,463.90	129,627,332.58	454	225	11,498,014,292.72	105,417,610.53

ТАТВАРЫН ЕРӨХИЙ ГАЗАР - ТАТВАР ТӨЛӨГЧИД ҮЙЛЧЛЭХ ГАЗАР

Хавсралт 4. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-3

/төгрөг/

Хувь хүний орлогын албан татвар төлөгч иргэдийн судалгааг 2019-2020 он

Байршил	Худалдааны төв	Худалдаа эрхлэгчид 2019 он						Худалдаа эрхлэгчид 2020 он					
		Бүртгэлтэй худалдаа эрхлэгчийн тоо	борлуулалтын орлого	тайлагнасан худалдаа эрхлэгчийн тоо	Ногдол	төлсөн татварын хэмжээ	Бүртгэлтэй худалдаа эрхлэгчийн тоо	борлуулалтын орлого	тайлагнасан худалдаа эрхлэгчийн тоо	Ногдол	төлсөн татварын хэмжээ		
Чингэлтэй дүүрэг	Алжин бөмбөгөр	585	691,172,997.00	21	3,570,328.40	50,221,843.20	598	2,389,180,058.70	215	10,219,860.40	19,431,240.00		
	Бөмбөгөр-1	213	474,357,053.80	16	2,218,461.00	16,129,706.00	394	1,693,288,315.00	75	18,565,042.00	31,763,125.70		
	Компьютер галд	78	137,056,294.00	9	498,460.30	1,167,083.70	78	158,068,597.70	11	1,095,128.80	700,273.40		
	Нарантуул-2	321	307,725,004.00	14	1,043,305.30	7,217,434.00	340	1,627,998,179.90	179	14,758,557.00	5,432,078.00		
	Нарлаг дэнж												
Сүхбаатар дүүрэг	Содон бөмбөгөр	113	30,173,854.30	3	200,000.00	3,834,792.00	206	457,418,822.20	70	3,140,172.10	4,144,000.00		
	Теди	268	4,821,534,098.00	162	61,845,706.70	94,051,715.20	342	10,101,715,548.90	298	105,242,148.60	21,212,742.90		
	Шонгор зах	212	525,792,656.60	15	1,705,486.70	11,342,732.00	427	1,652,646,737.70	64	5,003,186.20	1,412,000.00		
	100 айл төв	46	446,645,097.00	16	3,917,838.90	7,421,224.50	46	484,451,179.80	19	4,135,368.80	2,890,332.40		
	Саруул зах	57	6,315,413,846.40	27	36,078,629.90	12,139,755.90	51	4,298,002,623.60	35	9,996,997.90	11,546,145.70		
Баянзүрх дүүрэг	Монгол	28	555,282,000.00	22	4,205,140.00	2,776,000.00	31	524,319,262.80	26	2,544,707.80	3,660,150.00		
	Их нөмд						194	3,612,065,282.60	72	7,424,773.70	11,651,082.70		
	Баялаг Ундраа	1132	800,239,680.10	30	11,965,862.80	37,102,457.70	1132	3,837,264,036.40	117	28,686,151.50	49,283,240.00		
	Баянзүрх зах-2	153	255,256,263.10	4	345,609.30	8,636,206.20	157	553,738,376.20	24	2,116,796.40	1,148,122.80		
	Баянзүрх зах-1	59	588,165,242.50	23	2,690,697.00	4,702,106.00	60	1,383,244,619.20	52	11,545,535.50	4,840,000.00		
Баянгол дүүрэг	ДА ХҮРЭЭ ЗАХ	150	862,157,699.80	35	9,168,980.70	31,677,236.40	159	1,729,965,710.40	90	28,646,492.60	12,791,887.00		
	Дунжингарав худалдааны төв	505	1,915,618,748.80	72	11,717,278.90	37,047,852.00	512	4,362,122,807.90	219	30,325,716.30	9,446,000.00		
	Цайз худалдааны төв	22	224,742,630.00	8	3,338,231.30	2,600,000.00	21	394,097,776.70	10	6,463,315.20	1,340,000.00		
	Нарантуул	1710	16,452,647,585.20	177	87,396,236.50	265,606,315.60	1710	24,747,000,089.70	373	113,379,710.80	204,991,536.00		
	Өгөөмөр	550					550	65,511,247.00	1	3,959,498.20			
Сонгинохайрхан дүүрэг	САНДЭЙ худалдааны төв	525	1,526,538,783.70	38	7,434,018.70	52,188,513.60	551	2,463,799,289.30	158	39,344,344.30	19,419,569.90		
	Барс зах	107	112,480,938.70	7	497,940.40	5,291,200.00	116	421,926,509.90	10	1,465,398.40	1,680,000.00		
	Барс-2	19	86,434,817.00	4	124,153.00	6,075,800.00	19	280,206,524.60	8	393,536.20	1,251,045.00		
	Хархорин худалдааны төв	124	137,994,296.60	11	874,543.00	6,178,657.20	194	172,331,584.90	20	1,198,090.50	7,996,621.00		
	Шинэ Сандэй худалдааны төв	34	710,576,400.50	14	1,624,938.10	37,030,643.00	34	918,940,298.90	26	3,610,744.20	2,108,400.00		
Иргэн	Авто-22 худалдааны төв	185	31,551,768,877.50	37	31,641,322.60	44,282,845.90	184	26,762,356,183.00	59	33,218,066.30	18,688,366.40		
	Бархүү							29,000,000.00	1	215,600.00			
	Одончимэг							32,834,656.00	1	2,955,555.50	300,000.00		
	Одзаа		88,000,000.00	1	8,800,000.00	8,800,000.00		74,508,555.00	1	741,579.95			
	Уранжолбоо												
	Идэржавхлан												
	Оюн												
	Ариунболд		14,280,000.00	1	111,200.00	4,786,316.20		41,204,000.00	1	371,500.00			
	Оюн							109,774,805.04	1	2,165,000.00			
	Энхболд							30,972,892.76	1	748,000.01	437,920.00		
Сүхбаатар дүүрэг	Төгс												
	Сарнай		155,441,394.53	1	755,898.78	687,652.20		38,665,520.00	1	72,997.00			
	Болд		87,115,003.92	1	190,792.66			4,832,836.38	1	-	187,285.47		
Сүхбаатар дүүрэг	Нарантуяа /Наара/							100,038.50	1	10,003.85	10,003.85		

Хавсралт 5. ХХОАТ төлөгчийн тайлагналын ирц-2021-2022 он

Хувь хүний орлогын албан татвар төлөгч иргэдийн судалгааг 2021-2022 он													төгрөг/
Байршил	Худалдааны төв	Худалдаа эрхлэгчид 2021 он					Худалдаа эрхлэгчид 2022 он					төлсөн татварын хэмжээ	
		Бүртгэлтэй худалдаа эрхлэгчийн тоо	борлуулалтын орлого	тайлагнасан худалдаа эрхлэгчийн тоо	Ногдол	төлсөн татварын хэмжээ	Бүртгэлтэй худалдаа эрхлэгчийн тоо	борлуулалтын орлого	тайлагнасан худалдаа эрхлэгчийн тоо	Ногдол			
Чингэлтэй дүүрэг	Атлун бөмбөгөр	698	2,053,581,578.60	228	26,998,371.50	4,754,053.40	724	2,815,239,404.70	101	16,937,914.20	19,031,892.10		
	Бөмбөгөр-1	407	3,433,594,718.50	132	49,538,384.30	6,479,014.90	427	1,785,681,447.00	136	23,534,232.90	46,066,952.70		
	Компьютер лэнд	81	236,943,420.00	14	6,219,910.40	1,419,877.70	82	247,239,096.30	13	2,999,453.90	3,307,507.40		
	Нарангуул-2	368	2,048,126,064.40	173	11,977,663.80	22,747,616.50	424	3,163,855,906.00	175	16,646,662.30	1,842,800.00		
	Нарлаг дэнж	43	35,482,052.30	31	97,044.70	641,382.30	43	53,318,738.40	5	267,407.50	100,000.00		
	Содон бөмбөгөр	206	419,216,783.30	47	3,446,051.30	494,616.00	209	443,312,888.80	57	4,908,984.00	1,284,807.50		
	Теди	348	30,830,905,676.70	268	139,438,940.50	7,532,050.00	378	1,462,868,563.90	219	142,641,832.00	25,310,602.70		
	Шонгор зах	431	4,215,551,614.50	114	54,495,690.90	2,085,860.50	431	3,982,086,792.30	87	18,580,255.40	9,516,287.30		
	100 айл төв	42	776,195,159.20	24	4,847,484.10	5,885,570.30	49	1,625,073,252.80	22	7,390,265.20	6,372,144.40		
	Сэрүүл зах	111	16,276,313,424.20	50	36,460,498.30	23,109,527.80	111	20,401,177,993.40	49	59,185,713.50	40,808,388.00		
Сүхбаатар дүүрэг	Монгол	35	289,519,805.90	27	2,344,616.70	641,230.00	41	326,074,825.10	22	3,456,527.50	2,049,597.50		
	Их нямд	251	8,142,552,428.40	97	19,108,858.10	5,498,057.50	281	12,722,325,822.30	75	18,674,952.10	10,342,535.30		
	Баялаг Ундраа	1132	2,665,568,974.80	139	16,788,203.90	15,912,889.10	1132	11,335,729,359.10	129	22,963,945.90	115,741,518.80		
	Баянзүрх зах-2	159	413,999,523.30	13	1,399,574.70	614,056.50	158	376,046,533.40	16	2,890,391.20	2,070,313.10		
	Баянзүрх зах-1	61	2,340,747,483.40	70	24,191,037.00	10,391,179.10	61	2,535,583,348.70	72	11,408,853.90	11,185,875.60		
	ДА ХҮРЭЭ ЗАХ	167	4,152,456,394.10	70	5,854,851.10	8,832,962.40	178	3,920,376,697.90	109	33,968,548.20	4,759,464.30		
	Дунжингарав худалдааны төв	520	4,649,080,097.30	266	50,597,432.00	7,848,578.20	517	6,440,630,638.50	284	43,184,371.80	10,273,225.50		
	Цайз худалдааны төв	23	583,645,102.30	10	4,792,685.10	5,825,690.30	24	663,907,556.00	10	3,919,490.80	2,640,124.00		
	Нарангуул	1710	39,733,328,962.60	427	202,261,313.50	147,794,079.90	1710	37,140,534,737.20	417	295,279,539.60	333,481,322.40		
	Өгөөмөр	550	57,476,814.00	2	416,000.00		550	179,259,168.60	4	2,235,559.60			
Баянгол дүүрэг	САНДЭЙ худалдааны төв	580	16,113,882,484.40	163	37,079,457.80	2,938,318.40	610	8,443,598,475.40	140	37,670,632.80	10,045,980.30		
	Барс зах	269	346,693,726.80	11	1,058,133.70	2,770,971.10	164	422,397,765.40	17	5,106,760.40	1,705,065.50		
	Барс-2	87	717,350,613.70	10	10,162,609.30	183,553.00	124	317,402,776.70	11	550,501.50	9,553,542.90		
	Хархорин худалдааны төв	875	129,894,362.30	13	991,487.70	626,510.00	903	84,634,988.80	13	467,310.50	414,491.40		
	Шинэ Сандэй худалдааны төв	126	1,267,050,016.10	28	14,650,065.70	1,907,368.80	396	1,794,466,819.80	28	7,595,417.00	6,648,329.30		
	Авто-22 худалдааны төв	184	41,913,089,770.90	67	64,156,086.00	41,700,391.90	185	30,893,624,932.90	47	56,842,607.90	78,924,218.90		
	Бархүү							102,791,635.00	1	3,031,835.69	2,955,555.50		
	Одончимэг		-	1	371,800.30	75,000.00							
	Одояа		135,737,103.00										
	Уранхотбоо							27,920,000.00	1	542,000.00			
Иргэн	Идэржавхан							6,761,979.00	1	67,619.79			
	Оюун		32,000,000.00	1	320,000.00			31,500,000.00	1	315,000.00			
	Аринболд		12,400,497.00	1	210,000.00			9,765,341.08	1	0.01			
	Оюун							17,120,000.00	1	171,200.00			
	Энхболд										310,080.01		
	Төгс												
	Сарнай		89,444,966.00	1	43,636.40								
Сонгинохайрхан дүүрэг	Болд		45,314,784.00	1	453,147.84	190,792.66		41,383,250.00	1	413,832.50			
	Нарангууа /Наара/		12,000,000.00	1	120,000.00			49,800,000.00	1	498,000.00			

Хавсралт 6. Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023. 07. 25 № 03 / 5485
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/1333 тоот албан бичгээр ирүүлсэн “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хурлаас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан татварын шинэчлэлийн багц хууль хэрэгжиж эхэлснээс хойш 3 жилийн дараа энэхүү хуулийн шинэчлэлийн гүйцэтгэлд аудит хийж, хамтран ажиллаж байгаа явдалд талархлаа илэрхийлье.

Эдийн засаг, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг дэмжихэд татварын тогтвортой орчин чухал байдгийг харгалзан аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа урт хугацаанд төлөвлөх, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тодорхой эдийн засгийн мөчлөг, хөгжлийн үе шаттай уялдуулан 1992, 2006 болон 2019 онд татварын эрх зүйн орчны шинэчлэлийг хийсэн байдаг.

Улмаар Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дугаарт заасан албан татварын бодлогыг тодорхойлох онцгой бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн татварын хуулийн шинэчлэлд зохих өөрчлөлтийг тусган эцэслэн баталдаг билээ.

Гүйцэтгэлийн аудитад хамаарч буй 2019 оны татварын хуулийн шинэчлэлд татварын бодлогоор бизнесийн орчныг сайжруулах, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжихэд түлхэц үзүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх, татвараас зайлсхийх олон улсын зарчмуудыг нэвтрүүлэх, татвар төлөгчийг дэмжих, давхардсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зогсоох, оновчтой болгох зэрэг олон зорилтыг дэвшүүлсэн.

Эдгээрээс гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгагдаагүй, агуулгын хувьд дутуу, учир дутагдалтай тусгагдсан зарчмын голлох асуудлаар дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1.Татварын хуулийн шинэчлэл хэрэгжиж эхлэхийн өмнө Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг Бизнес эрхлэхүй 2019 тайланд дундаж хэмжээний аж ахуйн нэгж Монгол Улсад 25.7 хувийн татвар (үүнд нийгмийн даатгалын шимтгэл орсон) төлж байгаа нь дэлхийд 179 дүгээр бага татвартай улсад орсон байдаг. Энэ нь Зүүн Өмнөд Ази, номхон далайн бүс нутагт 33.6 хувь, Өмнөд Азийн бүс нутагт 43.9 хувь,

9766011012

Европ, Төв Азийн бүс нутагт 31.7, Латин Америк, Карибын бүс нутагт 47 хувь, Ойрхи дорнод, Өмнөд Африкт 32.5 хувь байгаатай харьцуулахад татварын ачаалал багатай улс байсныг харуулж байна.

Улмаар татварын шинэчлэлээр жижиг, дунд хэмжээний бизнес татварын ачааллыг улам багасгаж 1.5 тэрбум төгрөг хүртэл татвар ногдох орлоготой бол үйл ажиллагааны орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь, 6 тэрбум төгрөг хүртэл татвар ногдуулах орлоготой бол 10 хувь болгон бууруулсан билээ. Үүнээс хойш Монгол Улсын Засгийн газраас согтууруулах ундааны онцгой албан татвараас бусад аливаа татварын хувь хэмжээ, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг огт нэмэгдүүлээгүй болохыг та бүхэн анхаарахыг хүсье.

2. Татварын шинэчлэлийн томоохон зорилт болсон Цахим төлбөрийн баримтын систем (и-баримт)-ийн хөгжүүлэлтийн үр дүнд иргэд худалдан авалт хийхдээ төлбөрийн баримтаа шаардах нь нэмэгдэж, эцсийн хэрэглээний бүртгэл улам сайжирч, далд эдийн засаг буурах эерэг нөлөө үзүүлсэн. Үүний үр дүнд улсын төсөвт төвлөрч буй НӨАТ-ын орлогын хэмжээ 2022 онд 2016 оны төвшнөөс 3.4 дахин, НӨАТ суутган төлөгчийн тоо 2.5 дахин, хэвлэгдсэн төлбөрийн баримтын тоо 4.5 дахин, баталгаажуулсан төлбөрийн баримтын тоо 5.4 дахин нэмэгдсэн байна.

Мөн татварын бааз суурийг өргөжүүлэх, эцсийн хэрэглээний бүртгэлийг сайжруулах зорилгоор төлбөрийн баримтын сугалаат урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь эерэг нөлөө үзүүлсэн байна.

Ийнхүү татварын бүртгэл, мэдээллийн тогтолцоог хөгжүүлж, татварын үйл ажиллагааг хүний оролцооноос илүүтэй тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх боломж бүрдэж татвар төлөх, тайлагнах, татвар төлөгчтэй харилцах үйл ажиллагааг өнгөрсөн хугацаанд бүрэн цахимжуулаад байна. Ингэснээр татвар төлөгчдийн татварын хуулийг хэрэгжүүлэх, төлөх, тайлагнах зардлыг бууруулсан болно.

3.Татварын шинэчлэлийн томоохон нэг зорилт нь олон улсын татварын хамтын ажиллагаа, татвараас зайлсхийх, татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг олон улсын дүрэм, стандартуудыг хэрэгжүүлэх явдал байсан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг (BEPS) хөтөлбөр”, “Татварын зорилгоор ил тод байдал, харилцан мэдээлэл солилцох олон улсын форум”-д нэгдэн орсноор олон улсын татварын шинэчлэлийг хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна.

Ингэснээр Монгол Улс нь Европын холбооны Татварын зорилгоор хамтарч ажилладаггүй бүс нутгуудын жагсаалтаас гарахад шаардлагатай татварын бүхий л арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллаж чадсан.

ЭЗХАХБ, Уул уурхай, үнэт металл, тогтвортой хөгжлийн засгийн газар хоорондын форум (ЗГФ), ЭЗХАХБ/НҮБ-ын “Tax inspectors without borders” буюу Хил хязгааргүй татварын байцаагч (ХХТБ) хөтөлбөртэй Монголын татварын алба анх удаа хамтран ажиллаж, уул уурхайн салбарт татварын хяналт шалгалт хийх чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд байна. Уг хөтөлбөрийн үр дүнд Монголын татварын алба анхны үнэ шилжилтийн хяналт шалгалтыг хийж, ирээдүйд шилжүүлэн тооцох 1.5 тэрбум ам.долларын алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй бууруулах, 649 тэрбум төгрөг (ойролцоогоор 228 сая ам.доллар)-ийн татварын нөхөн ногдуулалт, акт, төлбөрийг үндэстэн дамнасан компанид ногдуулсан. ЭЗХАХБ-аас энэ нь Монгол

Улсын хувьд татварын суурийг багасгаж, ашгийг шилжүүлэхийн эсрэг бодлого хэрэгжүүлэхэд чухал алхам болсныг онцолсон ба ЗГФ-аас 2017 оны 6 дугаар сард хэвлэн гаргасан Уул уурхайн бодлогын хүрээний үнэлгээний тайланд Монгол Улсын татвар болон АМНАТ төлөлтийн мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг өндөр түвшинд байна гэж тус тус үнэлсэн байна.

Түүнчлэн, Монгол Улс татварын шинэчлэлээр тавьсан олон улсын татварын хамтын ажиллагаа, татвараас зайлсхийх явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, татварын ил тод байдлыг хангахад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд хөгжиж буй орнуудыг манлайлан идэвхтэй оролцож байна. Тодруулбал, Монгол Улсын Сангийн яамны төлөөлөл 2020-2022 онд ЭЗХАХБ-ын Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүнээр хөгжиж буй орнуудыг төлөөлөн сонгогдон ажилласан болно.

4.Татварын хуулийн шинэчлэлээр давхардсан татварын зарлага буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулах, татварын дэмжлэг үзүүлэх зарчмыг шинэчилж хариуцлагыг нэмэгдүүлсэн. Тухайлбал, хуулийн дагуу үзүүлдэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь зарим тохиолдолд үр ашиггүй, зорилтод бүлэгтээ хүрэхгүй байх эрсдэлтэй байдаг тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татвар төлөгч татварын тайлангаа гаргаж, татвараа төлсний дараа төлсөн татвараас нь буцаан олгох замаар эдлүүлдэг байх харилцааг нэвтрүүлсэн. Ингэснээр татвар төлөгч илүү хариуцлагатай болж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой болсон.

5.Татварын хуулийн шинэчлэл хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн дэлхий нийтэд гарсан цар тахлын болон олон улсын геополитикийн хурцадмал байдалд эдийн засаг хүндрэлтэй олон сорилттой тулгарч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаатай холбогдуулан татварын хуулийн шинэчлэлд заасан татвар хураалт, хяналт шалгалт гэх зэрэг зарим чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нөхцөл байдлыг та бүхэн аудитын тайландаа харгалзан үзэхийг хүсье.

Гэсэн хэдий ч эдийн засгийн энэ хүндрэлтэй цаг үед Монгол Улсын Засгийн газар 2019 оны татварын шинэчлэлээр тавьсан бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг нэмэхгүй дэмжлэг үзүүлэх, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулах, татвараас зайлсхийх явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, татварын үйлчилгээг цахимжуулах, татварын маргааны тоог бууруулах, олон улсын татварын зарчмуудыг хууль тогтоомждоо нэвтрүүлэх, татварын ил тод байдлыг хангах, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлд гаргасан үр дүнг та бүхэн анхаарч үзэхийг хүсье.

Үндэсний аудитын газраас “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 1/1 хуудас.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улаанбаатар хот, ЧД 4-р хороо,
Бага тойруу /15160/, С.Данзангийн гудамж 4А,
Утас: 7575-1288, E-mail: info@mta.gov.mn

2023. 07. 27 № 02/1660
танай 2023. 07. 07 -ны № 01/1353 -т


Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдвээр хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлд санал авахаар ирүүлсэн төсөлтэй танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал, тайлбарыг 1 дүгээр хавсралтаар, Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлд санал, талбайрыг 2 дугаар хавсралтаар, 3 дугаар хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт²² хуудастай.

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЭНХБОЛД

152342486

Татварын ерөнхий газрын 2023 оны 07 дугаар сарын
...-ны өдрийн ... тоот албан бичгийн ... дүгээр хавсралт

“Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдвээр хийгдсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгсөн саналын товчоо

Д/д	Төслийн заалт	Өгсөн санал
1	Төслийн 2 дугаар бүлгийн 2.1.3	Өөрчлөлт оруулах
2	Төслийн 2 дугаар бүлгийн 2.3.4	Нэмэлт оруулах
3	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.5	Өөрчлөлт оруулах
4	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.7	Өөрчлөлт оруулах
5	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.13	Өөрчлөлт оруулах
6	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.14	Өөрчлөлт оруулах
7	Төслийн 3 дугаар бүлгийн 3.2.5	Хасах
8	Төслийн 3 дугаар бүлгийн 3.2.8	Хасах
9	Төслийн 3 дугаар бүлгийн 3.3	Өөрчлөлт оруулах
10	Төслийн 3 дугаар бүлгийн 3.3.4	Нэмэлт оруулах
11	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.2	Өөрчлөлт оруулах
12	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.3	Өөрчлөлт оруулах
13	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.4	Өөрчлөлт оруулах
14	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.5	Нэмэлт оруулах
15	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.3	Өөрчлөлт оруулах
16	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.2	Өөрчлөлт оруулах
17	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3-д бүлгийн гарчиг	Өөрчлөлт оруулах
18	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3.2	Өөрчлөлт оруулах
19	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3.3	Хасах
20	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3.7	Хасах
21	Дүгнэлт	
21.1	3 дах хэсэгт	Өөрчлөлт оруулах
21.2	5 дах хэсэг	Хасах
21.3	6 дах хэсэг	Өөрчлөн найруулах
21.4	7 дах хэсэг	Өөрчлөлт оруулах
21.5	9 дэх хэсэг	Өөрчлөн найруулах
21.6	Дүгнэлтэд нэмэлт оруулах	3 санал
22	Зөвлөмжид өгөх санал	
22.1	Яам, агентлагийн чиг үүрэг, эрх мэдэл харилцан адилгүй учир, зөвлөмжөө 3 байгууллага тус бүрт салган бичүүлэх	
22.2	Хөрөнгийн татварын хуулийг шинэчлэх зөвлөмжийг СЯ-рүү өгүүлэх	
22.3	3 дах хэсэг	Хасах
22.4	5 дах хэсэг	Хасах



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас/Факс: (976-11) 35 00 60,
И-мэйл: info@customs.gov.mn, Вэбсайт: www.customs.gov.mn

2023. 07. 26 № 02/2657
танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2-д “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.1-11.2.3-т заасан салбарын улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын хийх хөрөнгө оруулагчийн тухайн төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 284, 2014 оны 317, 2015 оны 191, 2017 оны 191, 2019 оны 139, 2020 оны 176 дугаар тогтоолуудаар “Эрэл”ХХК, “Монцемент билдинг материалс”ХХК, ТОСК, “Вестернхолд”ХХК-ийн импортоор оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулсан гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаагаар хойшлуулах шийдвэр гарсан.

Засгийн газрын тогтоолын дагуу Сангийн яам, Барилга хот байгуулалтын яам болон “Эрэл” ХХК, “Монцемент билдинг материалс” ХХК, “Вестернхолд” ХХК-ийн хооронд хийгдсэн гуравласан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж нийт 41,8 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлтийг хийсэн.

Гэтэл дээрх гэрээний хэрэгжилт хангагдахгүй байгаагаас үүдэн гаалийн байгууллагад 39,8 тэрбум төгрөгийн хойшлуулсан татварын өр хуримтлагдаад байна. Гаалийн байгууллага нь хууль тогтоомжид заасан эрх үүргийн дагуу үүссэн өрийг барагдуулахаар бүхий л арга хэмжээг авч ажилласан бөгөөд 3 шатны шүүхийн шийдвэр хүртэл гарсан боловч шүүхийн шийдвэр хэрэгжихгүй өнөөг хүрээд байна.

Иймд Үндэсний аудитын газраас “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө”-нд хийсэн аудитаар Засгийн газрын шийдвэрээр хойшлуулсан татварын өрийн асуудалд гаалийн байгууллагад акт тавих гэж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь гаалийн байгууллага Засгийн газрын шийдвэрийн дагуу байгуулсан гэрээний оролцогч тал биш бөгөөд зөвхөн гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үүссэн өрийг барагдуулах чиглэлээр бүхий л арга хэмжээг авч ажиллаж байна.

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГЭЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН

1439607 2798

Хавсралт 7. Саналын шийдвэрлэлт, түүнд өгсөн тайлбар

Д/д	Тайлангийн хэсэг	Сангийн яамны өгсөн санал	Саналын шийдвэрлэлт, тайлбар
1	Ерөнхий мэдээлэл	Татварын хуулийн шинэчлэл хэрэгжиж эхлэхийн өмнө Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг Бизнес эрхлэхүй 2019 тайланд дундаж хэмжээний аж ахуйн нэгж Монгол Улсад 25.7 хувийн татвар (үүнд нийгмийн даатгалын шимтгэл орсон) төлж байгаа нь дэлхийд 179 дүгээр бага татвартай улсад орсон байдаг. Энэ нь Зүүн өмнөд ази, номхон далайн бүс нутагт 33.6 хувь, Өмнөх азийн бүс нутагт 43.9 хувь, Европ, төв азийн бүс нутагт 31.7, Латин америк, карибын бүс нутагт 47 хувь, Ойрхи дорнод, өмнөд африкт 32.5 хувь байгаагаар харьцуулахад татварын ачаалал багатай улс байсныг харуулж байна. Улмаар татварын шинэчлэлээр жижиг, дунд хэмжээний бизнес татварын ачааллыг улам багасгаж 1.5 тэрбум төгрөг хүртэл татвар ногдох орлоготой бол үйл ажиллагааны орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь, 6 тэрбум төгрөг хүртэл татвар ногдуулах орлоготой бол 10 хувь болгон бууруулсан билээ. Үүнээс хойш Монгол Улсын Засгийн газраас согтууруулах ундааны онцгой албан татвараас бусад аливаа татварын хувь хэмжээ, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг огт нэмэгдүүлээгүй болохыг та бүхэн анхаарахыг хүсье.	Саналыг харгалзан үзэж тайлангийн төслийн 2.2.3 “Татварын ачаалал өсөж байгаа нь татварын хувь хэмжээг шатлан бууруулах, бичил, жижиг бизнес эрхлэгчид, орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих “Татварын шинэчлэлийн бодлого”-ийн үр нөлөөг сааруулж, иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна” гэсэн дүгнэлтийг хассан.
2	Ерөнхий мэдээлэл	Татварын шинэчлэлийн томоохон зорилт болсон Цахим төлбөрийн баримтын систем (и-баримт)-ийн хөгжүүлэлтийн үр дүнд иргэд худалдан авалт хийхдээ төлбөрийн баримтаа шаардах нь нэмэгдэж, эцсийн хэрэглээний бүртгэл улам сайжирч, далд эдийн засаг буурах эерэг нөлөө үзүүлсэн. Үүний үр дүнд улсын төсөвт төвлөрч буй НӨАТ-ын орлогын хэмжээ 2022 онд 2016 оны төвшнөөс 3.4 дахин, НӨАТ суутган төлөгчийн тоо 2.5 дахин, хэвлэгдсэн төлбөрийн баримтын тоо 4.5 дахин, баталгаажуулсан төлбөрийн баримтын тоо 5.4 дахин нэмэгдсэн байна. Мөн татварын бааз суурийг өргөжүүлэх, эцсийн хэрэглээний бүртгэлийг сайжруулах зорилгоор төлбөрийн баримтын сугалаат урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь эерэг нөлөө үзүүлсэн байна. Ийнхүү татварын бүртгэл, мэдээллийн тогтолцоог хөгжүүлж, татварын үйл ажиллагааг хүний оролцооноос илүүтэй тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх боломж бүрдэж татвар төлөх, тайлагнах, татвар төлөгчтэй харилцах үйл ажиллагааг өнгөрсөн хугацаанд бүрэн цахимжуулаад байна. Ингэснээр татвар төлөгчдийн татварын хуулийг хэрэгжүүлэх, төлөх, тайлагнах зардлыг бууруулсан болно.	Татварын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээлэл, технологийн хөгжүүлэлт, сайжруулалт, түүнээс бий болсон үр өгөөжийг талаар бүлэг 5-д тодорхой дурсан. и-баримтын олголт зарим сектор хангалттай үр дүнд хүрээгүй тул аудитын нотлох баримт, үр дүнд үндэслэлгүй шууд мэдээлэл оруулах боломжгүй байна.
3	Ерөнхий мэдээлэл	Татварын шинэчлэлийн томоохон нэг зорилт нь олон улсын татварын хамтын ажиллагаа, татвараас зайлсхийх, татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг олон улсын дүрэм, стандартуудыг хэрэгжүүлэх явдал байсан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг (BEPS) хөтөлбөр”, “Татварын зорилгоор ил тод байдал, харилцан мэдээлэл солилцох олон улсын форум”-д нэгдэн орсноор олон улсын татварын шинэчлэлийг хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна. Ингэснээр Монгол Улс нь Европын холбооны Татварын зорилгоор хамтарч ажилладаггүй бүс нутгуудын жагсаалтаас гарахад шаардлагатай татварын бүхий л арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллаж чадсан.	Эдгээр үр нөлөөг бид аудитын тайлангийн 5.4.5-т тусгасан.

		ЭЗХАХБ, Уул уурхай, үнэт металл, тогтвортой хөгжлийн засгийн газар хоорондын форум (ЗГФ), ЭЗХАХБ/НҮБ-ын “Tax inspectors without borders” буюу Хил хязгааргүй татварын байцаагч (ХХТБ) хөтөлбөртэй Монголын татварын алба анх удаа хамтран ажиллаж, уул уурхайн салбарт татварын хяналт шалгалт хийх чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд байна. Уг хөтөлбөрийн үр дүнд Монголын татварын алба анхны үнэ шилжилтийн хяналт шалгалтыг хийж, ирээдүйд шилжүүлэн тооцох 1.5 тэрбум ам.долларын алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй бууруулах, 649 тэрбум төгрөг (ойролцоогоор 228 сая ам.доллар)[1]-ийн татварын нөхөн ногдуулалт, акт, төлбөрийг үндэстэн дамнасан компанид ногдуулсан. ЭЗХАХБ-аас энэ нь Монгол Улсын хувьд татварын суурийг багасгаж, ашгийг шилжүүлэхийн эсрэг бодлого хэрэгжүүлэхэд чухал алхам болсныг онцолсон ба ЗГФ-аас 2017 оны 6 дугаар сард хэвлэн гаргасан Уул уурхайн бодлогын хүрээний үнэлгээний тайланд Монгол Улсын татвар болон АМНАТ төлөлтийн мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг өндөр түвшинд байна гэж тус тус үнэлсэн байна.	Саналын дагуу тайлангийн 5.4.7-д “Монголын татварын алба анхны үнэ шилжилтийн хяналт шалгалтыг хийж, ирээдүйд шилжүүлэх 1.5 тэрбум ам.долларын алдагдлыг бууруулан тооцож, 649 тэрбум төгрөгийн татварыг үндэстэн дамнасан компанид ногдуулсан байна” гэж нэмж тусгав.
4	Ерөнхий мэдээлэл	Татварын хуулийн шинэчлэлээр давхардсан татварын зарлага буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулах, татварын дэмжлэг үзүүлэх зарчмыг шинэчилж хариуцлагыг нэмэгдүүлсэн. Тухайлбал, хуулийн дагуу үзүүлдэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь зарим тохиолдолд үр ашиггүй, зорилтод бүлэгтээ хүрэхгүй байх эрсдэлтэй байдаг тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татвар төлөгч татварын тайлангаа гаргаж, татвараа төлсний дараа төлсөн татвараас нь буцаан олгох замаар эдлүүлдэг байх харилцааг нэвтрүүлсэн. Ингэснээр татвар төлөгч илүү хариуцлагатай болж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой болсон.	Аудитын тайлангийн төслийн 3.3.7, 3.3.8, 3.3.9, 3.3.10, 3.3.11, 3.3.12, 3.1.13- хэсэгт татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд гарсан өөрчлөлт, аудитын нотлох болон ажлын баримтад үндэслэсэн дүн, дүгнэлтүүдийг оруулсан болно.
5	Ерөнхий мэдээлэл	Татварын хуулийн шинэчлэл хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн дэлхий нийтэд гарсан цар тахлын болон олон улсын геополитикийн хурцадмал байдалд эдийн засаг хүндрэлтэй олон сорилттой тулгарч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаатай холбогдуулан татварын хуулийн шинэчлэлд заасан татвар хураалт, хяналт шалгалт гэх зэрэг зарим чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нөхцөл байдлыг та бүхэн аудитын тайландаа харгалзан үзэхийг хүсье. Гэсэн хэдий ч эдийн засгийн энэ хүндрэлтэй цаг үед Монгол Улсын Засгийн газар 2019 оны татварын шинэчлэлээр тавьсан бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг нэмэхгүй дэмжлэг үзүүлэх, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулах, татвараас зайлсхийх явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, татварын үйлчилгээг цахимжуулах, татварын маргааны тоог бууруулах, олон улсын татварын зарчмуудыг хууль тогтоомждоо нэвтрүүлэх, татварын ил тод байдлыг хангах, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлд гаргасан үр дүнг та бүхэн анхаарч үзэхийг хүсье.	Дээрх нөлөөллийг аудитын дүгнэлтэд харгалзан үзсэн болно. Тухайлбал: Бүлэг 4. татварын өр 2022 оны байдлаар 3,276.6 тэрбум төгрөг болж өссөн нь ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан тухай дүгнэлтийн хэсэгт тусгасан.
6	9 дүгээр хуудсанд	засах	“Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилттэй холбоотойгоор Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын чиг үүргээс татварын “бодлого”-ын чиглэлийг салгаж, Татварын бодлогын газрыг шинээр бий болгосон байна. Саналыг хүлээн авч тусгасан.

7	1 дүгээр бүлгийн 1.2.9	“...татварын шинэчлэлийн үзэл баримтлалд бүрэн нийцэхгүй...” гэж хууль тогтоомжид тусгагдаагүй, тодорхойгүй баримт бичиг дурдсан байх тул хасах	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль, Монгол улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулиудыг <u>ТЕХ-ийн шинэчлэлтэй холбогдуулан өөрчлөөгүй</u> . Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, Нохойны албан татвар, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн албан татварын тухай хуулийг шинээр боловсруулахаар <u>хуульд тусгасан байна</u> . Өөрчлөн найруулсан.
8	1 дүгээр бүлгийн 1.1.4	Төслийн 1 дүгээр бүлгийн 1.1.4-т “Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн хөтөлбөрийн төлөвлөлтийг судалгаа, шинжилгээнд үндэслэж бодитоор тооцоолоогүй, эрх зүйн зохицуулалтгүйгээс хэрэгжээгүй байна.” гэсэн нь үндэслэлгүй байна. Хувь хүний орлогын албан татварын дараагийн шатны шинэчлэлээр зайлшгүй авч үзэх асуудал юм.	Аудитын төслийн агуулга нь ТЕГ-с авсан нотлох баримтын хүрээнд боловсруулагдсан. 1.1.4-г Харин “хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн хөтөлбөр нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан хэрэгжих хугацааг хойшлуулсан байна. Саналыг тусгав.
9	1 дүгээр бүлгийн 1.1.8	Төслийн 1.1.8-д “Ажлын байр олноор бий болгоход татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх” зорилт үр дүнтэй хэрэгжээгүй байна.” гэжээ.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлээр нийт 1.2 их наяд төгрөг буюу төсвийн орлогын 6 орчим хувьтай тэнцэх хэмжээний татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу татварын дэмжлэгийг татвар төлөгч нарт үзүүлсэн бөгөөд энэ хэмжээгээр бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын байрыг хадгалахад эерэг нөлөө үзүүлсэн.	1.1.8 Аудитаар үнэлгээг дахин нягтлахад “ажлын байр олноор бий болгоход татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх” зорилтын хэрэгжилт, үр дүн тодорхойгүй байна. Саналыг тусгав
10	1 дүгээр бүлгийн 1.1.9	Татварын дэмжлэгийг ашиглах эсэх нь татвар төлөгч өөрийн үйл ажиллагаандаа уялдуулан төлөвлөж, татварын ногдлоо өөрөө тодорхойлж тайлагнадаг тул төслийн дээрх заалтыг хасах саналтай байна.	Өөрчлөн найруулсан.
11	2 дугаар бүлгийн 2.2.1	Төслийн 2 дугаар бүлгийн гарчиг болон 2.2.1, 2.2.3 нь үндэслэлгүй байна. Монгол Улс нь 2019 онд татварын шинэчлэлийг хэрэгжүүлснээс хойших хугацаанд согтууруулах ундааны онцгой албан татвараас бусад тохиолдолд 1 татварын хувь хэмжээг огт нэмэгдүүлээгүй бөгөөд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулсан билээ.	2.2.3 “Татварын ачаалал өсөж байгаа нь татварын хувь хэмжээг шатлан бууруулах, бичил, жижиг бизнес эрхлэгчид, орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих “Татварын шинэчлэлийн бодлого”-ын үр нөлөөг сааруулж, иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна”-хэсгийг саналын дагуу хассан.
12	2 дугаар бүлгийн 2.3.4	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олсон орлогоос 18 дугаар зүйлийн 18.4-т заасан зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасаж 20 дугаар зүйлийн 20.1-т заасны дагуу 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна гэж заасан тул дээрх хэсгийг хуульд нийцүүлэн засах нь зүйтэй байна.	2.3.4-т “...төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олох орлогын албан татварыг 15 хувь бууруулж 25 хувь” хэсэгт саналын дагуу засвар хийсэн.
13	3 дугаар бүлгийн 3.1.1	“Шинэчлэн найруулсан ТЕХ-аар 13 албан татвар, 14 төлбөр, 3 хураамж, нийт 30 нэр төрлийн татварыг ногдуулж, төвлөрүүлэхээр зааснаас 8 төрлийн татварын орлогыг улсын төсөвт, 16 төрлийн татварын орлогыг орон нутгийн төсөвт, 3 төрлийн татварын болон татварын бус орлогыг улс болон орон нутгийн төсөвт хувь тооцон хуваарилж байна.” гэснийг хуульд нийцүүлэн засах нь зүйтэй байна.	3.1.1-д ..., 15 төрлийн татварын орлогыг орон нутгийн төсөвт, 4 төрлийн татварын болон татварын бус орлогыг улс болон орон нутгийн төсөвт хувь тооцон хуваарилж байна гэж саналын дагуу ТОХ-ын дарга Л.Ичинноровоос тодруулсны дагуу өөрчлөлт оруулсан.

14	2 дугаар бүлгийн 2.3.4	Түүнчлэн, жилийн 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд татвар ногдуулах орлогын 1 хувиар татвар төлөх, 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн төлсөн орлогын татварын 90 хувийг буцаан олгох зэргээр жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан олон тооны татварын дэмжлэг туссан. Энэ зохицуулалтын хүрээнд 2020 онд 297 татвар төлөгч 2.0 тэрбум төгрөг, 2021 онд 2491 татвар төлөгч 36.6 тэрбум төгрөг, 2022 онд 3,933 татвар төлөгч 59.2 тэрбум төгрөг, нийт 6,721 татвар төлөгчид 97.8 тэрбум төгрөгийг буцаан олгосон тул энэ талаар тайланд тусгах саналтай байна. /нэмж тусгуулах санал/	2.3.4-т нэмж тусгав
15	3 дугаар бүлгийн 3.1.2	хасах	3.1.2-т Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, Нохойны албан татвар, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн албан татварын тухай хуулийг шинээр боловсруулахаар ТЭХ-д тусгасан байна. Саналыг тусгаж, найруулгад өөрчлөлт хийсэн
16	3 дугаар бүлгийн 3.1.6	10.Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.6-д тусгасан татварын хөнгөлөлтийн дүн зөрүүтэй байна. Тухайлбал, “ААНОАТТХ-ийн шинэчилсэн зохицуулалтын дагуу алслагдсан бүсийн 2020 онд 49 татвар төлөгчид <u>2.3</u> тэрбум төгрөг, 2021 онд 57 татвар төлөгчид <u>3.3</u> тэрбум төгрөг, 2022 онд 85 татвар төлөгчид 2.1 тэрбум төгрөг, нийт 191 татвар төлөгчид 7.7 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлж, буцаан олгосон байна” гэж өөрчлөх саналтай байна.	3.1.6-д 2.2 тэрбум гэснийг 2.3, 3.2 тэрбум гэснийг 3.3 тэрбум болгож оронгийн нарийвчлалыг 0.1-р өөрчлөн зассан.
17	3 дугаар бүлгийн 3.1.9	хасах	3.1.9- г Гадаадын иргэн, харьяатын газрын 2019-2022 онд хураасан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 10 дугаар зүйлийн 10.6-т заасан Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд оршин суух зөвшөөрөл олгох, виз сунгах, визний нөхцөлийг өөрчлөх, байнгын болон түр оршин суух зөвшөөрөл олгох үйлчилгээний 5.1 тэрбум төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.9-дэх заалттай нийцэхгүй байна гэж найруулга дээр өөрчлөлт хийсэн. Асуудлын бүртгэлийн албан шаардлагыг зөвлөмж болгов.
18	3 дугаар бүлгийн 3.1.14	Энэ нь Улсын Их Хурлаас 2019 онд баталсан татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд бус нийслэл хотын эрх зүйн байдлыг шинэчлэх багц хуулийн хүрээнд орсон хуулийн өөрчлөлт юм. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас бүрэн чөлөөлдөг байсныг өөрчилж, “иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц”-ыг албан татвараас чөлөөлөхөөр тусгасан. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотод бүртгэлтэй 2 хүртэлх орон сууцыг албан татвараас чөлөөлж, 3 болон түүнээс дээш орон сууцанд албан татвар ногдуулахаар заасан бөгөөд албан татварын дээд хувь хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 0.6-2 хувь болгосон болно.	3.1.15-д татварын хувь болон зохицуулалт хийгдэх болсон шалтгааныг саналын дагуу өөрчилсөн.
19	3 дугаар зүйлийн 3.1.15	хасах	3.1.16-ТЭГ-ын нэмэлт тайлбар тодруулга авсны үндсэн дээр агуулгын хувьд томоохон зөрүүгүй тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн.
20	3 дугаар зүйлийн 3.2.1	Төслийн 3.2.1, 3.2.2 дэх заалтыг хасах саналтай байна.	Төрийн аудитын байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд, аудитыг эрсдэлд суурилж, төлөвлөн хэрэгжүүлдэг тул саналын дагуу хасах боломжгүй гэж үзсэн

21	3 дугаар зүйлийн 3.2.2	хасуулах	Энэхүү асуудал нь аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатанд хийсэн судалгаанд үндэслэн аудитын багаар шийдвэрлэсэн хамрах хүрээнд тодорхойлогдсон бөгөөд МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг өөрчилж, аудитын дүнгээс хасах боломжгүй юм. Харин энэ асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэснийг санал, тайлбарт үндэслэн цуцалсан.
22	3 дугаар зүйлийн 3.2.4	Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд Татварын хувь хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл тогтоосон хязгаарт багтаан тогтоож болно гэж заасан байна. Харин Малын тоо толгойн албан татвар, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгогдсон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл тогтоохоор заасан.	Саналын дагуу өөрчлөлтийг хийсэн.
23	3 дугаар зүйлийн 3.2.6	Төслийн 3.2.6-д Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2-т аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д олгосон бүрэн эрхийг үгүйсгэсэн байна.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр хуулиар олгогдсон эрх, хэмжээндээ татварын хувь, тарифыг ялгамжтай байдлаар тогтоож байна. Саналын дагуу агуулгын өөрчлөлт хийсэн
24	3 дугаар зүйлийн 3.2.8	хасах	Саналыг тусгаж, найруулга дээр засвар хийв.
25	3 дугаар зүйлийн 3.3.14	18. Төслийн 3.3.14-д заасныг дараах үндэслэлээр засах нь зүйтэй байна. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-т “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ гэж, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т “татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана” гэж тус тус заасны дагуу тайлагнаж байна. Татварын зарлагын мэдээг жил бүр тайлагнаж гаргах нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр нөлөөг үнэлэх, статистик мэдээллийг бодитой гаргах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээллийг хүргэх, төсвийн орлогын бүртгэл орон зайг бодитой тооцоход ашигладаг.	3.3.14-д Сангийн яам уг орлогыг нь МУНТГТ-ын тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн боловч татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр нөлөөг үнэлэх, статистик мэдээлэл бэлтгэж олон нийтэд мэдээлэх зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр тайлагнасан байна гэж өөрчлөв. Саналыг харгалзан найруулгын засвар хийв.
26	3 дугаар зүйлийн 3.3.6	Цахим төлбөрийн баримт олголт татварын шинэчлэл хэрэгжиж эхлэхээс өмнөх 2019 онтой харьцуулахад 2022 онд 80 хувиар өссөн байна. Мөн төлбөрийн баримт олголтыг сайжруулах зорилгоор Цахим төлбөрийн баримтын системд (и-баримт) дараах шинэчлэлийг хийсэн ба энэ нь иргэд худалдан авалт хийхдээ төлбөрийн баримтаа шаардах нь нэмэгдэж, эцсийн хэрэглээний бүртгэл улам сайжирч, далд эдийн засаг буурах эерэг нөлөө үзүүлсэн. Энэ хэсгийг хасах саналтай.	3.3.6-д “Худалдаа эрхлэгчид борлуулалтын 24 орчим хувьд цахим и-баримт олгосон байна” гэж саналыг харгалзан өөрчлөн найруулсан.
27	4 дүгээр зүйлийн 4.1.2	Татвар төлөгч иргэн, хуулийн этгээд хуулиар ногдуулсан татварыг хугацаандаа төлөөгүйгээс татварын өрийн хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 3,176.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Өрийн насжилтыг авч үзвэл 2022 онд үүссэн өрийн үлдэгдэл 1,752.0 тэрбум төгрөг, 2021 он болон түүнээс өмнөх онд үүссэн өрийн үлдэгдэл 1,524.6 тэрбум төгрөг байна гэж өөрчлөн найруулах.	СЯ-с ирүүлсэн өрийн шинэчилсэн үлдэгдэл зөрүүтэй байх тул ТЕГ-с авсан судалгааны дагуу дараах өөрчлөлт оруулав. Аудитын хяналтын эрсдэлийг бууруулах зорилгоор 4.1.11, 4.1.12 хэсгийг нэмж тусгав.
28	4 дүгээр зүйлийн 4.1.3	21. Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.3-т “Нийт өрийн үлдэгдлийн 40.6 хувь дотоодын бараа, үйлчилгээнд суутгасан НӨАТ, 20.6 хувь ААНОАТ, 15.0 хувь АМНАТ, 23.0 хувь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын, 0.8 хувь бусад татварын өр байна.” гэснийг “Нийт өрийн үлдэгдлийн 40.5 хувь дотоодын бараа, үйлчилгээнд суутгасан НӨАТ, 19.2 хувь ААНОАТ, 17.0 хувь АМНАТ, 22.2 хувь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын, 1.0 хувь бусад татварын өр байна.” гэж өөрчлөх саналтай байна.	Татварын өрийн үлдэгдлийг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хувь хэмжээнд орсон өөрчлөлтийг саналын дагуу засаж оруулсан

29	4 дүгээр зүйлийн 4.1.4	Татварын өрийн үлдэгдлийн судалгаагаар 46.53 хувь буюу 1,524.6 тэрбум төгрөг нь 2021 оноос өмнө буюу Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөгөөр үүссэн, 53.47 хувь буюу 1,752.0 тэрбум төгрөг нь 2022 оны тайлант оны өр байна. Эргэн төлөгдөхөд хүндрэлтэй, барагдуулахад цаг хугацаа их шаардах өрийн дүн 877.8 тэрбум төгрөг байна гэж өөрчлөх саналтай байна	Саналыг харгалзан өрийн статистик үзүүлэлтийг дахин хянаж, өөрчилсөн.
30	5 дугаар зүйлийн 5.4.1	Монгол Улс нь 1991-2007 оны хооронд нийт 35 улстай Давхар татварын гэрээ (ДТГ) байгуулсан бөгөөд үүнээс 4 улстай ДТГ-гээ цуцалж, одоогоор 26 ДТГ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэ нь 2019 оны татварын шинэчлэлийн хүрээнд байгуулагдсан хэлэлцээрүүд биш юм. алдаатай тайлбарласан тул засах нь зүйтэй байна.	Саналыг тусгав.
31	Дүгнэлтийн 3 дугаарт	“Улсын Их Хурлаас 2019 онд нэгэнт баталсан татварын хуулийн шинэчлэлийн хэрэгжилтийг сайжруулах, боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг авах” гэж өөрчлөх саналтай байна.	Татварын багц хуулиудыг шинэчлэн баталж, холбогдох 28 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч зарим татварын хуулийг шинэчлэх, тодорхойгүй зохицуулалтуудыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна гэж агуулгад өөрчлөлт хийсэн.
32	Дүгнэлтийн 4 дүгээрт	“Татварын орлого улсын төсвийн нийт орлогын 70 хувийг бүрдүүлж, жил бүр өсөж байгаа хэдий ч эдийн засаг дахь татварын ачаалал болон инфляцын түвшин өсөж байгаатай уялдахгүй байна” гэсэн нь агуулгын хувьд зөрчилтэй, үндэслэлгүй байна. Иймд дүгнэлтийн энэ хэсгийг өөрчлөн тодорхой болгох, эсхүл хасах саналтай байна.	Татварын нийгэм, эдийн засаг, иргэд аж, ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөөллийг судалж үнэлэх, татварын ачааллыг салбар, сегментийн хэмжээнд тооцож, дүн шинжилгээ хийн татварын болон төсвийн бодлоготой уялдуулан зохицуулах шаардлагатай байна. Дүгнэлтэд саналыг тусгав.
33	Дүгнэлтийн 5 дугаарт	Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хуультай зөрчилдөх эрсдэлтэй байна. Улсын болон орон нутгийн төсөв хоорондын харилцааг Төсвийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлаас жил бүр хуульчлан баталдаг бөгөөд үүний дагуу холбогдох харилцаа зохицуулагдаж байна. Үүнтэй холбогдуулан зөвлөмжийн 3 дахь хэсгийг өөрчлөх саналтай байна.	Саналыг харгалзан үзэж, эрх зүйн зохицуулалтын хувьд хоёрдмол шинжтэй дүгнэлтийг хассан.
34	Дүгнэлтийн 9 дүгээрт	“Татварын албадан гүйцэтгэх ажиллагаа бусад салбарын хуультай уялдаа сул байгаагаас хангалттай үр дүнд хүрч чадахгүй байна.” гэжээ. Төрийн байгууллага Монгол Улсын аливаа хуулийг дагаж мөрдөн хэрэгжүүлдэг байх үүрэгтэй боловч татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй, эс үйлдэл гаргаж байгаа тохиолдолд энэхүү аудитын үр дүнд албан шаардлага, зөвлөмж хүргүүлэх замаар татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах саналтай байна.	Дүгнэлттэй зарчмын хувьд саналын зөрүү байхгүй гэж үзэн хэвээр үлдээсэн.
35	Зөвлөмж 1 дүгээрт	Зөвлөмжийн 1 дүгээрт Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, Нохойны албан татвар, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн тухай хуулийг боловсруулж батлуулахыг заажээ. Энэхүү албан бичгээр хүргүүлж буй саналын 9 дэх хэсгээр хүргүүлсэн тайлбарын дагуу энэ асуудлыг тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэх нь зүйтэй тул найруулгын өөрчлөлт хийх саналтай байна.	Зөвлөмжийн агуулгад саналыг тусгав

Д/д	Тайлангийн хэсэг	Татварын ерөнхий газрын өгсөн санал	Саналын шийдвэрлэлт, тайлбар
1	Төслийн 2 дугаар бүлгийн 2.1.3	Өөрчлөлт оруулах	Саналыг тусгав
2	Төслийн 2 дугаар бүлгийн 2.3.4	Нэмэлт оруулах	Саналыг тусгав
3	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.5	Өөрчлөлт оруулах	Найруулгад өөрчлөлт оруулав
4	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.7	Өөрчлөлт оруулах	Хэрэглэгчид ойлгомжтой байдлаар томъёолсон тул 3.1.8-д өгсөн саналыг тусгах шаардлагагүй гэж үзсэн
5	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.13	Өөрчлөлт оруулах	Аудитын тайланд санал нь агуулгын хувьд тусгагдсан бөгөөд аудитын үр дүнг бууруулах эрсдэлтэй тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн.
6	Төслийн 3 дугаар бүлгийн 3.1.14	Өөрчлөлт оруулах	Энэ хэсэгт Сангийн яамнаас ирүүлсэн саналыг тусгасан, агуулгын хувьд зөрүүгүй мэдээлэл байх тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн.
7	Төслийн 3 дугаар бүлгийн 3.2.5	Хасах	Тарифын зөрүүний асуудлыг хөндөж тавьсан бөгөөд тайлангийн 3.2.4-т хуулиар олгогдсон эрхийн дагуу тогтоож байгаа тухай тусгасан. Иймд агуулгын хувьд зөрүүгүй тул саналыг тусгах шаардлагагүй байна.
8	Төслийн 3 дугаар бүлгийн 3.2.8	Хасах	Саналын дагуу хасах шаардлагагүй гэж үзэж, агуулгын хувьд зөрүүтэй хэсгийг өөрчлөн найруулсан.
9	Төслийн 3 дугаар бүлгийн 3.3	Өөрчлөлт оруулах	Аудитын нотлох баримтаар батлагдсан асуудлыг агуулгын хувьд дордуулж өөрчлөх боломжгүй тул саналыг тусгах шаардлагагүй гэж үзсэн
10	Төслийн 3 дугаар бүлгийн 3.3.4	Нэмэлт оруулах	Саналыг тусгав
11	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.2	Өөрчлөлт оруулах	Татварын өрийн үлдэгдлийг ирүүлсэн тайлбар, судалгаа, саналд үндэслэн өөрчлөн тусгав. Харин аудитын хамрах суурь он 2019 оны үзүүлэлтийг өөрчлөх боломжгүй юм.
12	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.3	Өөрчлөлт оруулах	Саналыг тусгав
13	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.4	Өөрчлөлт оруулах	Өрийн үлдэгдлийн дүнг шинэчилсэн дүнгээр оруулж, интервалыг суурь 2019 оноос өмнөх, хойд гэж хэвээр үлдээсэн.
14	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.5	Нэмэлт оруулах	Дагалдах судалгаа, тооцоолол, мэдээллээ ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй болгож байна.
15	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.3	Өөрчлөлт оруулах	Саналыг тусгав
16	Төслийн 4 дүгээр бүлгийн 4.1.2	Өөрчлөлт оруулах	Өөрчлөлтийг тусгасан тохиолдолд аудитын чанар, агуулга, батламж мэдэгдэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул саналыг тусгах боломжгүй гэж үзсэн.
17	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3-д бүлгийн гарчиг	Өөрчлөлт оруулах	Саналыг тусгав
18	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3.2	Өөрчлөлт оруулах	Саналыг тусгав
19	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3.3	Хасах	Саналыг тусгав
20	Төслийн 5 дугаар бүлгийн 5.3.7	Хасах	Саналыг тусгав
21	Дүгнэлтийн хэсэг		
21.1	3 дах хэсэгт	Өөрчлөлт оруулах	Хөрөнгийн хуулиас гадна 3 албан татварын тухай хуулийг баталж хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул Саналыг авах шаардлагагүй гэж үзсэн.
21.2	5 дах хэсэг	Хасах	Саналыг хүлээн авч хассан
21.3	6 дах хэсэг	Өөрчлөн найруулах	Саналыг тусгав
21.4	7 дах хэсэг	Өөрчлөлт оруулах	Саналыг тусгав
21.5	9 дэх хэсэг	Өөрчлөн найруулах	Саналыг тусгав
21.6	Дүгнэлтэд нэмэлт оруулах	3 санал	Аудитын тайланд энэ тухай тодорхой тусгасан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
22	Зөвлөмжийн хэсэг		
22.1	Яам, агентлагийн чиг үүрэг, эрх мэдэл харилцан адилгүй учир, зөвлөмжөө 3 байгууллага тус бүрд салган бичүүлэх		Саналыг тусгав

22.2	Хөрөнгийн татварын хуулийг шинэчлэх зөвлөмжийг СЯ-рүү өгүүлэх		Саналыг тусгав
22.3	3 дах хэсэг	Хасах	Саналыг тусгав
22.4	5 дах хэсэг	Хасах	Аудитын нотлох баримт, нэмэлт тайлбар тодруулгад үндэслэн өөрчлөн найруулсан

Д/д	Тайлангийн хэсэг	Гаалийн ерөнхий газрын өгсөн санал	Саналын шийдвэрлэлт, тайлбар
1	3 дугаар бүлгийн 3.3.15	Үндэсний аудитын газраас Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө сэдэвт аудитаар Засгийн газрын шийдвэрээр хойшлуулсан татварын өрийн асуудалд гаалийн байгууллагад акт тавих гэж байгааг хүлээн авах боломжгүй байна. Учир нь гаалийн байгууллага Засгийн газрын шийдвэрийн дагуу байгуулсан гэрээний оролцогч тал биш бөгөөд зөвхөн гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үүссэн өрийг барагдуулах чиглэлээр бүхий л арга хэмжээг авч ажиллаж байна. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт агентлаг, түүний чиг үүргийг “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.” гэж тодорхойлсон бөгөөд гаалийн байгууллага нь Засгийн газрын шийдвэрийн дагуу гаалийн болон бусад татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлтийг хийсэн.Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ.”, 13.3. “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ бусдад гэм хор учруулсан, зах зээлийн харилцааны чөлөөт байдлыг үндэслэлгүйгээр хязгаарласан, хууль ёсны давуу байдлаа хууль бусаар ашигласан үйл ажиллагаа явуулж болохгүй бөгөөд хэрэв зөрчвөл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ” гэж тус тус заасан бөгөөд Засгийн газрын шийдвэрийн дагуу байгуулсан гэрээний оролцогч талуудад Гаалийн байгууллага аливаа эрх зүйн эрх эдэлж, үүрэг хүлээн оролцоогүй. Өөрөөр хэлбэл гэрээ байгуулсан аль нэг тал биш юм.	Санал, тайлбарыг дараах хууль эрх зүйн зохицуулалтын улмаас хүлээн авах боломжгүй байна. Үүнд: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т “Гаалийн болон бусад татварыг барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тариф, валютын ханшаар тооцож төгрөгөөр ногдуулах ба хэрэв бичиг баримтын бүрдүүлэлтийг урьдчилан хийсэн өдрөөс гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх өдөр хүртэлх хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш болон тарифын хувь хэмжээнд өөрчлөлт орсон бол гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа тариф, валютын ханшийг баримтална”, 46 дугаар зүйлийн 46.1-д “Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан хугацаанд, эсхүл мөн хуулийн 41 дүгээр зүйлд заасан баталгааны дагуу гаалийн болон бусад татвар төлөөгүй бол тэдгээрийг хураах ажиллагааг Татварын ерөнхий хуулийн дагуу хэрэгжүүлнэ”, 46.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 46.1-д заасан ажиллагааг гаалийн байгууллагад ажиллаж буй гаалийн улсын байцаагчийн эрх бүхий этгээд хэрэгжүүлж болно” гэж заасны дагуу Татварын ерөнхий хуулийн 58-71 дүгээр зүйлд заасан шат дараалсан арга хэмжээг ГЕГ-с хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзсэн.